

**МОНГОЛ УЛСЫН ДИЖИТАЛ (ТООН) ТАХОГРАФЫН
СИСТЕМИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
БОДЛОГО (АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО)**

УЛААНБААТАР, МОНГОЛ УЛС

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1 ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА	5
1.2 БАТАЛГААЖУУЛАЛТ (ЗӨВШӨӨРӨЛ).....	6
1.3 ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ БОЛОН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ	6
2. ХАМРАХ БОЛОН ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ	6
3. НИЙТЛЭГ ЗААЛТ	8
3.1 ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	8
3.1.1 МН-ЭББ болон МН-КОБ-ын хүлээх үүрэг.....	8
3.1.2 МН-ГОБ-ын хүлээх үүрэг	8
3.1.3 МН-КМОБ-ын хүлээх үүрэг	8
3.1.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх үүрэг	9
3.1.5 Карт эзэмшигчийн хүлээх үүрэг.....	9
3.1.6 Тээврийн Хэрэгсэл үйлдвэрлэгчийн хүлээх үүрэг (КМОБ-ын хувьд хүлээх үүрэг)	10
3.1.7 Хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгчийн хүлээх үүрэг (КМОБ-ын хувьд хүлээх үүрэг)	10
3.2 ХАРИУЦЛАГА.....	10
3.2.1 МН-ЭББ болон МН-КОБ-ын хэрэглэгч болон хамаарах талуудын өмнө хүлээх хариуцлага ...	10
3.2.2 МН-ГОБ болон МН-КМОБ-ын МН-ЭББ болон МН-КОБ-ын өмнө хүлээх хариуцлага	10
3.3 ТАЙЛБАР БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ	10
3.3.1 Мөрдлөг болгох хууль.....	10
3.4 НУУЦЛАЛ.....	10
3.4.1 Нууцлах мэдээлэлийн төрөл.....	10
3.4.2 Нууцад тооцогдохгүй мэдээлэлийн төрөл	10
4. АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ (АЖ)	11
5. ТӨХӨӨРӨМЖИЙН УДИРДЛАГА	11
5.1 ТАХОГРАФЫН КАРТ	11
5.1.1 Чанарын хяналт – МН-ГОБ /МН-КМОБ-ын чиг үүрэг	11
5.1.2 МН-КОБ-ын чиг үүрэг - карт авах хүсэлт гаргах	11
5.1.3 МН-КОБ-ын чиг үүрэг - картыг сунгах	13
5.1.4 МН-КОБ-ын чиг үүрэг - картыг шинэчлэх юмуу солих	14
5.1.5 Хаясан, хулгайлагдсан, гэмтсэн, ажиллахгүй картыг солих	14
5.1.6 МН-КОБ-ын чиг үүрэг - хүсэлтийн зөвшөөрөлийг бүртгэх	14
5.1.7 МН-КМОБ-ын чиг үүрэг – картад мэдээлэл оруулах	14
5.1.8 МН-КМОБ болон МН-КОБ-ын чиг үүрэг - картын бүртгэл болон өгөгдөлийн хадгалалт	15

5.1.9 МН-КМОБ болон МН-КОБ-ын чиг үүрэг - картыг хэрэглэгчдэд түгээх (хуваарилах)	15
5.1.10 МН-КМОБ-ын үүсгэсэн таньж баталгаажуулах код (ПИН)	15
5.1.11 МН-ЭББ/МН-КОБ болон МН-КМОБ-ын чиг үүрэг - картыг идэвхгүй болгох	16
5.2 ТЭЭВЭРИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ХӨДӨЛГӨӨН МЭДРЭГЧ	16
6. СУУРЬ ТҮЛХҮҮРҮҮД БОЛОН ДАМЖУУЛАЛТЫН ТҮЛХҮҮРИЙН УДИРДЛАГА: ЕВРОПЫН СУУРЬ ТҮЛХҮҮР, МОНГОЛ УЛСЫН ТҮЛХҮҮРҮҮД, ХӨДӨЛГӨӨН МЭДРЭГЧИЙН ТҮЛХҮҮРҮҮД, ДАМЖУУЛАЛТЫН ТҮЛХҮҮРҮҮД	16
6.1 ЕСГБ-ЫН НИЙТИЙН ТҮЛХҮҮР	17
6.2 МОНГОЛЫН ТҮЛХҮҮРҮҮД.....	17
6.2.1 Монголын түлхүүрүүд үүсгэх.....	17
6.2.2 Монголын түлхүүрүүдийн хүчинтэй хугацаа.....	17
6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт	17
6.2.4 Монголын хувийн түлхүүрийн нөөц хуулбар	18
6.2.5 Монголын хувийн түлхүүрийг хадгалуулах.....	18
6.2.6 Монголын түлхүүрүүд эрсдэлд орох.....	18
6.2.7 Монголын түлхүүрүүд дуусгавар болох	18
6.3 ХӨДӨЛГӨӨН МЭДРЭГЧИЙН ТҮЛХҮҮРҮҮД.....	18
6.4 ДАМЖУУЛАЛТЫН ТҮЛХҮҮРҮҮД.....	19
6.5 ТҮЛХҮҮРТ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ХҮСЭЛТ БОЛОН ХӨДӨЛГӨӨН МЭДРЭГЧИЙН ТҮЛХҮҮРИЙГ ТҮГЭЭХ (ХУВААРИЛАХ) ХҮСЭЛТ	19
7. ТӨХӨӨРӨМЖИЙН ХОС ТҮЛХҮҮР (ТЭГШ БУС)	20
7.1 МН-ГОБ БОЛОН МН-КМОБ, ТҮҮНИЙ ДОТОР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН ТЭЭВЭРИЙН ХЭРЭГСЭЛ (ТХ) ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ АСУУДАЛ	20
7.2 ТӨХӨӨРӨМЖИЙН ТҮЛХҮҮР ҮҮСГЭХ	20
7.2.2 Төхөөрөмжийн түлхүүрийн хүчинтэй хугацаа	21
7.2.3 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийн хамгаалалт, хадгалалт - Картууд	21
7.2.4 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийн хамгаалалт, хадгалалт – ТХ.....	21
7.2.5 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хадгалуулах болон архивлах	21
7.2.6 Төхөөрөмжийн нийтийн түлхүүрийг архивлах.....	21
7.2.7 Төхөөрөмжийн хос түлхүүр дуусгавар болох	22
8. ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА	23
8.1 ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ	23
8.1.1 Тахографын картууд	23
8.1.2 Тээвэрийн хэрэгсэл (ТХ).....	23
8.2 ТАХОГРАФЫН КАРТЫН ГЭРЧИЛГЭЭ	23

8.2.1 Жолоочийн гэрчилгээ	23
8.2.2 Засвар үйлчилгээний газарын гэрчилгээ	23
8.2.3 Хяналтын гэрчилгээ.....	23
8.2.4 Компанийн (тээвэрийн) гэрчилгээ	23
8.3 ТЭЭВЭРИЙН ХЭРЭГСЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ	23
8.4 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА	23
8.5 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ.....	23
8.6 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭГ ШИНЭЧЛЭН СУНГАХ, ШИНЭЧЛЭХ	23
8.7 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ БОЛОН МЭДЭЭЛЭЛИЙГ ТҮГЭЭХ (ХУВААРИЛАХ)	24
8.8 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ АШИГЛАЛТ	24
8.9 ТӨХӨӨРӨМЖИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ.....	24
9. MNG-СА БОЛОН MNG-СР МЭДЭЭЛЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН УДИРДЛАГА	25
9.1 МН-ГОБ БОЛОН МН-КМОБ -ЫН МЭДЭЭЛЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН УДИРДЛАГА ..	25
9.2 МН-ГОБ БОЛОН МН-КМОБ -ЫН ЭД ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ БОЛОН УДИРДЛАГА	25
9.3 МН-ГОБ БОЛОН МН-КМОБ -ЫН АЖИЛТАНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН ХЯНАЛТУУД.....	25
9.3.1 Итгэмжлэгдсэн үүрэг роль	25
9.3.2 Үүрэг ролийг салган тусгаарлах	26
9.3.3 Үүрэг роль бүрийг адилтгах болон баталгаажуулах	26
9.3.4 Суурь мэдээлэл, мэргэшил, туршлага, ажилд авахад тавигдах шаардлага	26
9.3.5 Сургалтын шаардлагууд.....	27
9.4 ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БАЙГУУЛЛАГА (ГОБ) БОЛОН МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН ХЯНАЛТУУД.....	27
9.4.1 Компьютерийн аюулгүй байдалын техникийн шаардлагууд.....	27
9.4.2 Компьютерийн аюулгүй байдалын зэрэглэл-үнэлгээ	27
9.4.3 Системийн хөгжүүлэлтэд тавих хяналтууд	27
9.4.4 Аюулгүй байдалын удирдлагын хяналтууд.....	27
9.4.5 Сүлжээний аюулгүй байдалын хяналтууд.....	27
9.5 АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН АУДИТЫН ДЭГ	28
9.5.1 Бүртгэх үйл явдалын төрөл	28
9.5.2 Аудитын бүртгэлийг боловсруулах давтамж	28
9.5.3 Аудитын бүртгэлийг хадгалах хугацаа	28
9.5.4 Аудитын бүртгэлийг хамгаалах	28
9.5.5 Аудитын бүртгэлийг нөөцлөх дэг	28
9.5.6 Аудитын бүртгэл цуглуулах систем (дотоод болон гадаад)	28

9.6 ТАЙЛАН БИЧЛЭГИЙГ АРХИВЛАХ	28
9.6.1 МН-КМОБ-ын бүртгэх үйл явдалын төрөл	28
9.6.2 МН-ГОБ/МН-КМОБ-ын бүртгэх үйл явдалын төрөл	29
9.6.3 Архивыг хадгалах хугацаа	29
9.6.4 Архивын мэдээлэлийг олж авах болон шалган баталгаажуулах дэг	29
9.7 МН-ГОБ БОЛОН МН-КМОБ -ЫН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	29
9.7.1 Монголын түлхүүрүүд эрсдэлд орох	29
9.7.2 Бусад гамшигийн дараа сэргээх	29
9.8 ГОБ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ СИСТЕМИЙН БИЕТ АЮУЛГҮЙ БАЙДАЛЫН ХЯНАЛТУУД	30
9.8.1 Биеэр хандах хандалт	30
10. МН-ГОБ ЮМУУ МН-КМОБ АЖИЛЛАГААГАА ДУУСГАВАР БОЛГОХ	31
10.1 АЖИЛЛАГААГАА БҮРЭН ДУУСГАВАР БОЛГОХ – МН-ЭББ-ЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	31
10.2 МН-ГОБ ЮМУУ МН-КМОБ-ЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ ШИЛЖҮҮЛЭХ	31
11. АУДИТ	32
11.1 НИЙЦЭЛИЙН АУДИТЫН ДАВТАМЖ	32
11.2 АУДИТААР ШАЛГАХ СЭДЭВҮҮД	32
11.3 АУДИТ ГҮЙЦЭТГЭХ ЭТГЭЭД	32
11.4 АЛДАА ГАЖУУДАЛЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	32
11.5 ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ	32
12. ГОББ-ЫГ ӨӨРЧЛӨХ ДЭГ	33
12.1 МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭЛГҮЙ ӨӨРЧИЛЖ БОЛОХ ЗҮЙЛС	33
12.2 МЭДЭГДЭЛИЙН ҮНДСЭН ДЭЭР ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ	33
12.2.1 Мэдэгдэл	33
12.2.2 Санал ирүүлэх хугацаа	33
12.2.3 Хэнд мэдээлэх вэ	33
12.2.4 Өөрчлөлтийн талаар эцсийн мэдэгдэл гаргах хугацаа	33
12.3 ГОББ-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ШААРДЛАГА ҮҮСГЭДЭГ ӨӨРЧЛӨЛТ	33
13. НОМ ЗҮЙ	34
14. НЭР ТОМЪЁНЫ ТАЙЛБАР/ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ТОВЧЛОЛ	35
14.1 НЭР ТОМЪЁО/ТОДОРХОЙЛОЛТ	35
14.2 ТОВЧЛОЛ	36
15. ЕСГБ-ЫН БОДЛОГОТОЙ НИЙЦЭХ НИЙЦЭЛИЙН ХҮСНЭГТ	37

1. Танилцуулга

Энэ баримт бичиг нь Дижитал тахограф системийн гэрчилгээ болгох Монголын Үндэсний Гэрчилгээ Олгох Байгууллагын бодлого (цаашид ҮГОББ гэх) болон ажиллагааны журамдын талаарх мэдэгдэл (цаашид АЖ гэх) болно. Үндэсний Гэрчилгээ Олгох Байгууллагын бодлого (ҮГОББ) нь дараах баримт бичигтэй нийцэн боловсруулагдсан:

- Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр (AETR)” 1970.07.01;
- Европын Комисс болон НҮБ-ын Европын эдийн засагийн комиссын хооронд байгуулсан үйлчилгээний талаар харилцан ойлголцолын санамж бичиг, 2009.01 сар;
- Европын Комиссын Авто тээвэрт ашигладаг бичлэгийн төхөөрөмжийн талаарх 2002 оны 6-р сарын 13-ны өдрийн 1360/2002 дүрэм (зохицуулалт), 2004 оны 3-р сарын 5-ны 432/2004 дүрэм
- Тоон (дижитал) тахограф систем. ЕХ-ны үндсэн бодлого. Хувилбар 2.1. Европын Комиссын Хамтын судалгааны төвийн 2009 оны 07-р сарын 28-ны 53429 нийтлэл. <http://dct.jrc.ec.europa.eu>; “Зөвлөмж болон бодлогын загвар. Тахограф системийн Түлхүүр, гэрчилгээ болон төхөөрөмжийн удирдлага (бүртгэл, түлхүүр үүсгэх, гэрчилгээ олгох, карт олгох, түгээх (хуваарилах) , ашиглах, дуусгавар болгох)”;
- Авто тээврийн салбарт тахограф ашиглах 165/2014 дүрэм (ЕХ), Европын Зөвлөлийн Автотээврийн хэрэгсэлд бичлэг хийх төхөөрөмжийн тухай (ЕЕС) 3821/85 тоот журмыг хүчингүй болгож, 561/2006 тоот журамд нэмэлт оруулах.
- Европын Комиссын 2016 оны 03-р сарын 18-ны өдрийн 2016/799 дугаарт дүрэм, Европын парламент болон Зөвлөлийн 165/2014 дугаарт хэрэгжүүлэлтийн дүрэм
- 165/2014 дугаарт хэрэгжүүлэлтийн зохицуулалтад нэмэлт оруулах тухай Европын Комиссын 2018 оны 02-р сарын 28-ны өдөрийн 2018/502 дугаарт дүрэм
- ETSI TS 102 042 “Нийтийн түлхүүрийн гэрчилгээ олгож буй гэрчилгээжүүлэх байгууллагын бодлогод тавигдах шаардлага”
- Үндэсний ГОБ-ын бодлогын удирдамж болон жишиг. Хувилбар 1.0
- Европын Дижитал тахографын аюулгүй байдалын нийтлэг удирдамж. Хувилбар 1.0. 2002.11.05
- Дижитал тахограф системийн талаарх Европын суурь бодлого, Хувилбар 2.1; <https://dct.jrc.ec.europa.eu/> дээр нийтлэгдсэн.
- Монгол Улсын Засагийн Газарын тогтоол. 2021 оны .. сарын Дугаар.....
- Монгол Улсын Зам, Тээврийн Хөгжилийн яамны сайдын тушаал. 2021 оны ... сарын ... өдөр, Дугаар. " Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр (AETR)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Зам, Тээврийн Хөгжилийн яамны сайдын тушаал. 2021 оны ... сарын ... өдөр, Дугаар. "Тахографын Гэрчилгээ олгох, карт үйлдвэрлэх, олгох байгууллагыг томилох тухай”
- гэх мэтээр

1.1 Хариуцах байгууллага

"Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын

хэлэлцээр (AETR)” -т нэгдсэнтэй холбоотой үүргүүдийг хариуцан хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болохын хувьд Монгол Улсын **Зам, Тээвэрийн Хөгжилийн Яам** (цаашид **МН-ЭББ¹** гэх) Энэхүү ГОББ-ыг хариуцана.

Томилогдсон карт олгох байгууллага (**КОБ**) нь **ЗТХЯ-ны харьяа “Авто Тээвэрийн Үндэсний Төв”** төрийн өмчит үйлдвэрийн газар байна. (цаашид **МН-КОБ²** гэх).

Томилогдсон гэрчилгээ олгох байгууллага (**ГОБ**) нь **ЗТХЯ-ны харьяа “Авто Тээвэрийн Үндэсний Төв”** төрийн өмчит үйлдвэрийн газар байна. (цаашид **МН-ГОБ³** гэх).

Томилогдсон картанд мэдээлэл оруулах байгууллага (**КМОБ**) нь **ЗТХЯ-ны харьяа “Авто Тээвэрийн Үндэсний Төв”** төрийн өмчит үйлдвэрийн газар байна. (цаашид **МН-КМОБ⁴** гэх).

ЗТХЯ-ны харьяа “Авто Тээвэрийн Үндэсний Төв” төрийн өмчит үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны нэг хэсэг болох картыг олгох, түлхүүр үүсгэх, гэрчилгээ олгох, картанд мэдээлэл оруулах чиг үүрэгийг МН-ГОБ, МН-КМОБ -ын туслан гүйцэтгэгч мэргэшсэн байгуулагатай гэрээ байгуулан хариуцуулж болно. Эдгээр туслан гүйцэтгэгчийг цаашид **“Үйлчилгээ үзүүлэгч”** гэнэ. Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг ашиглах нь МН-ГОБ, МН-КМОБ -ын нийт үүрэг хариуцлагыг бууруулахгүй.

МН-ГОБ, МН-КМОБ -ын үйлчилгээ үзүүлэгч томилогдсон дараах байгууллага байна:

Тахографын системийн хос түлхүүр үүсгэх, гэрчилгээ олгох байгууллага

Мон Пасс СА тоон гарын үсэгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөлтэй байгууллага

Монгол улс, Улаанбаатар хот 13370,
БЗД, 18-р хороо, Манлайбаатар
Дамдинсүрэнгийн гудамж, 14/4

Карт үйлдвэрлэх, мэдээлэл оруулах байгууллага

.....

¹ **МН-ЭББ** – Монгол Улсын эрх бүхий байгууллага болох ЗТХЯ

² **МН-КОБ** – Монголын карт олгох байгууллага

³ **МН-ГОБ** – Монголын гэрчилгээ олгох байгууллага

⁴ **МН-КМОБ** – Монголын Картын мэдээлэл оруулах байгууллага (Картанд эзэмшигчийн мэдээлэл оруулах, карт дээрх зураг, мэдээлэлийг хэвлэн буулгах чиг үүрэгтэй)

1.2 Баталгаажуулалт зөвшөөрөл

Энэхүү ГОББ-ыг Европын Комисст зориулан дараах хаягт байрлах Дижитал тахографын Европын Суурь Гэрчилгээжүүлэх Байгууллагаас 2022. ..-р сарын .. өдөр баталгаажуулан зөвшөөрөв.

Digital Tachograph Root Certification Authority
Traceability and Vulnerability Assessment Unit
European Commission

Joint Research Centre, Ispra Establishment
(TR.360) Via E. Fermi, 1

I-21020 Ispra (VA)

1.3 Хүртгээмжтэй байдал болон холбоо барих мэдээлэл

Энэхүү ГОББ-ыг <http://www.mrtd.gov.mn> хаягаар нийтэд хүртгээмжтэй байршуулсан.

ГОББ-той холбоотой асуултыг дараах хаягаар хандаж авна:

ЗТХЯ-ны харьяа “Авто Тээвэрийн Үндэсний Төв (цаашид АТҮТ гэх)” ТӨҮГ

Монгол Улс, Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 976,

2. Хамрах болон хэрэглэх хүрээ

Энэхүү ГОББ нь зөвхөн тахографын системд хүчинтэй, хамааран үйлчилнэ.

МН-ГОБ-ын олгож буй хос түлхүүр болон гэрчилгээ нь зөвхөн тахографын системд ашиглагдана. Сисемээс олгосон карт нь зөвхөн тахографын системд ашиглагдана.

ГОББ-ын харах хүрээг дараах зурагт харуулсан.

Зурагт ашигласан товчлолын тайлал:

CSR – Certificate Signing Request-Гэрчилгээнд гарын үсэг зурах хүсэлт

KDM – Key Distribution Message- Түлхүүр түгээх (хуваарилах) тухай мессаж

KDR – Key Distribution Request – Түлхүүр түгээх (хуваарилах) хүсэлт

CSP – Certificate Service Provider – Гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлэгч (ГҮҮ)

KCR – Key Certificate Request – Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт

RSA – Rivest, Shamir and Adleman - том бүхэл тоог факторинг хийх тооцоололд суурилсан нээлттэй түлхүүр бүхий криптографын алгоритм

SK – Secret Key – Хувийн түлхүүр (ХТ)

PK – Public key – Нийтийн түлхүүр (НТ)

C – Certificate – Гэрчилгээ, N.C – Үндэсний гэрчилгээ

N.C – National certificate – Үндэсний гэрчилгээ

PK – Public Key – Нийтийн түлхүүр


MC – Mongolian Certificate – Монголын гэрчилгээ

MCA – Mongolian Certification Authority – Монголын Гэрчилгээ олгох (гэрчилгээжүүлэх) байгууллага МН-ГОБ

ERCA – European Root Certification Authority – Европын суурь гэрчилгээ олгох (гэрчилгээжүүлэх) байгууллага

AJ – Practice statement - Ажиллагааны журам (мэдэгдэл)

Eq – Equipment - Төхөөрөмж



3. Нийтлэг заалт

Энэ бүлэгт МН-ЭББ, МН-КОБ, МН-ГОб, МН-КМОБ, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн хүлээх үүрэгийн талаар заалтууд болон хууль тогтоомж, маргаан шийдвэрлэхтэй холбоотой заалтыг тодорхойлсон.

3.1 Хүлээх үүрэг

Энэ хэсэгт дараах байгууллагын хүлээх үүрэгийг тодорхойлсон:

- МН-ЭББ болон МН-КОБ
- МН-ГОб болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага (хэрэв гэрээт туслан гүйцэтгэгч байгаа бол)
- МН-КМОБ болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага (хэрэв гэрээт туслан гүйцэтгэгч байгаа бол)
- Хэрэглэгч (Карт эзэмшигч, ТХ үйлдвэрлэгч, хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгч)

3.1.1 МН-ЭББ болон МН -КОБ-ын үүрэг

Энэ бодлоготой хамааралтайгаар МН-ЭББ болон МН-КОБ дараах үүрэгийг хүлээнэ:

МН-ЭББ дараах үүрэгийг заавал биелүүлнэ:

- a) ГОББ-ыг нягтлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- b) МН-ГОб болон МН-КМОБ-ыг томилох;
- c) Томилогдсон МН-ГОб, МН-КМОБ болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагад аудит хийх;
- d) МН-ГОб, МН-КМОБ -ын ажиллагааны журамыг (АЖ)-ыг батлах;
- e) Хамааралтай талуудад энэ бодлогын талаар мэдээлэх;
- f) Энэ бодлогыг Европын Комиссоор батлан зөвшөөрүүлэх.

МН-КОБ дараах үүрэгийг заавал биелүүлнэ:

- a) Хүсэлт гаргах явцад МН-ГОб болон МН-КМОБ-д хэрэглэгчийн талаархи үнэн зөв, цаг хугацаандаа нийцсэн мэдээлэл очсон гэдэгийг баталгаажуулах.
- b) Хэрэглэгчдэд, тухайлбал карт эзэмшигч, тээвэрийн хэрэгсэл, хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгч, нийлүүлэгчид системийг ашиглахтай холбоотой бодлогын шаардлагуудын талаар мэдээлэх.

3.1.2 МН-ГОб-ын үүрэг

Томилогдсон МН-ГОб дараах үүрэгийг заавал биелүүлнэ:

- a) Энэ бодлогыг даган мөрдөх.
- b) МН-ГОб-ын ажиллагааны журамыг (МН-ГОб АЖ) нийтлэх. АЖ-ыг МН-ЭББ батлах бөгөөд энэ бодлогыг ишлэл болгосон байна.
- c) ГОББ-д тусгасан шаардлагууд, ялангуяа хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээх эрсдэлтэй холбоотой шаардлагын дагуу ажиллах зохион байгуулалт, санхүүгийн нөөцөөр хангах, хадгалах.

Энэ бодлогод тодорхойлсон бүх шаардлага хангагдсан байхыг МН-ГОб баталгаажуулна.

МН-ГОб-ын чиг үүрэгийг туслан гүйцэтгэгч – үйлчилгээ үзүүлэгч байгууллага гүйцэтгэж

байсан ч энэ бодлогод тодорхойлсон дэгийг сахин мөрдөх үүрэгийг МН-ГОВ хүлээнэ. Үйлчилгээ үзүүлэгч энэ бодлого болон ГОВ-ын АЖ-ын дагуу үйлчилгээг үзүүлэхийг МН-ГОВ хариуцаж хангана.

3.1.3 МН-КМОБ-ын үүрэг

Томилогдсон МН-КМОБ (картанд эзэмшигчийн болон бусад мэдээлэл оруулах, зураг мэдээлэл хувлан буулгах) дараах үүрэгийг заавал биелүүлнэ:

- a) Энэ бодлогыг даган мөрдөх.
- b) МН-ГОВ-ын ажиллагааны журамыг (МН-ГОВ АЖ) нийтлэх. АЖ-ыг МН-ЭББ батлах бөгөөд энэ бодлогыг ишлэл болгосон байна.
- c) ГОВБ-д тусгасан шаардлагууд, ялангуяа хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээх эрсдэлтэй холбоотой шаардлагын дагуу ажиллах зохион байгуулалт, санхүүгийн нөөцөөр хангах, хадгалах.

Энэ бодлогод тодорхойлсон бүх шаардлага хангагдсан байхыг МН-КМОБ баталгаажуулна.

МН-КМОБ-ын чиг үүрэгийг туслан гүйцэтгэгч – үйлчилгээ үзүүлэгч байгууллага гүйцэтгэж байсан ч энэ бодлогод тодорхойлсон дэгийг сахин мөрдөх үүрэгийг МН-КМОБ хүлээнэ.

3.1.4 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үүрэг

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага МН-ГОВ юмуу МН-КМОБ, хэрэглэгчийн өмнө гэрээний дагуу бүрэн үүрэг хүлээнэ.

3.1.5 Карт эзэмшигчийн үүрэг

МН-КМОБ-аас гэрээний дагуу (5.1.2-ыг үзнэ үү) дараах үүрэгийг биелүүлэхийг хэрэглэгчид үүрэг болгоно:

- a) Энэ бодлогын шаардлагын дагуу үнэн зөв, бүрэн мэдээлэлийг, ялангуяа бүртгэлтэй холбоотой мэдээлэлийг МН-КМОБ-д гаргаж өгөх;
- b) Түлхүүр болон гэрчилгээг зөвхөн Тахографын системд ашиглах;
- c) Картыг зөвхөн Тахографын системд ашиглах;
- d) Төхөөрөмжийн хувийн түлхүүр болон картыг зөвшөөрөлгүй ашиглахаас сэргийлэх зохистой арга хэмжээ авах;
- e) Зөвхөн өөрийн хос түлхүүр, гэрчилгээ болон картыг ашиглах (дүрэмийн 14.4.a);
- f) Хэрэглэгч жолоочийн зөвхөн нэг хүчинтэй карттай байх (Дүрэмийн 14.4.a);
- g) Зөвхөн онцгой, үндэслэлтэй тохиолдолд хэрэглэгч засвар үйлчилгээний газарын болон тээврийн компанийн карттай (Хавсралт 1B VI:1), эсхүл засвар үйлчилгээний газарын болон жолоочийн карттай, эсхүл хэд хэдэн засвар үйлчилгээний газарын карттай байж болно.
- h) Гэмтсэн эсхүл хугацаа дууссан картыг ашиглахгүй байх (Дүрэмийн 14.4.a);
- i) Гэрчилгээнд заасан хугацаа дуусахаас өмнө дараах зүйлсийн аль нэг тохиолдсон бол хэрэглэгч нэн даруй МН-КМОБ-д мэдэгдэнэ:
 - төхөөрөмжийн хувийн түлхүүр юмуу карт алдагдсан, хаясан, хулгайлагдсан юмуу эвдлэгдсэн (дүрэмийн 15.1); эсхүл
 - гэрчилгээний агуулга буруу байгаа, эсхүл буруу болсон.

3.1.6 ТХ үйлдвэрлэгчийн үүрэг (КМОБ-ын үүрэг роль гүйцэтгэгчийн хувьд)

Одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй.

3.1.7 Хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгчийн үүрэг (КМОБ-ын үүрэг роль гүйцэтгэгчийн хувьд)

Одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй.

3.2 Хариуцлага

МН-ГОБ болон МН-КМОБ эцсийн хэрэглэгчийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй, зөвхөн МН-ЭББ болон МН-КОБ-ын өмнө хариуцлага хүлээнэ. Эцсийн хэрэглэгчийн өмнө хүлээх аливаа хариуцлагын асуудал МН-ЭББ/МН-КОБ-ын үүрэг байна.

Тахографын карт, түлхүүр, гэрчилгээг зөвхөн тахографын системд ашиглана, тахографын картад бичигдсэн аливаа өөр гэрчилгээ нь энэ бодлогын заалтыг зөрчсөн зүйл гэж тооцогдоно, тиймээс МН-ЭББ, МН-КОБ, МН-ГОБ болон МН-КМОБ-ын аль нь ч энэ талаар хариуцлага хүлээхгүй.

3.2.1 МН-ЭББ болон МН-КОБ-ын хэрэглэгч, хамааралтай талуудын өмнө хүлээх хариуцлага

МН-ЭББ болон МН-ГОБ зүй бус, хайхрамжгүй ажилласан тохиолдолд үүрэгээ биелүүлээгүйн улмаас учирсан хохиролын хариуцлагыг хүлээнэ. Хэрэв МН-ЭББ юмуу МН-КОБ энэхүү бодлого, бусад зохицуулах баримт бичигийн дагуу ажилласан бол зүс бус, хайхрамжгүй ажиллагаа гэж тооцогдохгүй.

3.2.2 МН-ГОБ болон МН-КМОБ-ын МН-ЭББ болон МН-КОБ-ын өмнө хүлээх хариуцлага

МН-ГОБ болон МН-КМОБ зүй бус, хайхрамжгүй ажилласан тохиолдолд үүрэгээ биелүүлээгүйн улмаас учирсан хохиролын хариуцлагыг хүлээнэ. Хэрэв байгууллага энэхүү бодлого болон хамаарах АЖ, бусад зохицуулах баримт бичигийн дагуу ажилласан бол зүс бус, хайхрамжгүй ажиллагаа гэж тооцогдохгүй.

3.3 Тайлбар болон хэрэгжүүлэлт

3.3.1 Мөрдлөг болгох хууль

Монгол Улсад дижитал тахограф нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудалыг Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу шийдвэрлэнэ.

3.4 Нууцлал

Нууцлалыг ЕХ-ны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” болон Монгол улсын “Хувийн мэдээлэл хамгаалах” тухай хуулийн дагуу хангана.

3.4.1 Нууцлах мэдээлэлийн төрөл

МН-ГОБ, МН-КМОБ юмуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хадгалагдаж байгаа, олгосон карт болон гэрчилгээнд тусгагдаагүй аливаа хувь хүний болон байгууллагын мэдээлэл нууц гэж тооцогдох бөгөөд хуулинд өөрөөр заагаагүй бол хэрэглэгч (боломжтой бол), ажил олгогч юмуу хэрэглэгчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр задлахыг хориглоно.

МН-ГОБ/МН-КМОБ-ын ашиглаж, боловсруулж буй бүх хувийн түлхүүрийг энэ бодлогын дагуу нууцлан хадгална. Аудитын бүртгэл болон бичлэгийг хуулинд заасанаас бусад тохиолдолд нийтэд ил болгохгүй.

3.4.2 Нууцад тооцогдохгүй мэдээлэлийн төрөл

Гэрчилгээг нууц мэдээлэлд тооцохгүй.

Хууль болон тусгай гэрээгээр шаардаагүй бол Карт болон гэрчилгээнд тусгагдсан адилтгах

болон хувь хүн, байгууллагын бусад мэдээлэл нууцад тооцогдохгүй.

4. Ажиллагааны журам -мэдэгдэл (АЖ)

Энэ Бодлого (ГОББ) болон Ажиллагааны журамд (АЖ) тусгасан бүх шаардлагыг хангахын тулд МН-ГОБ болон МН-КМОБ үйл ажиллагааны журам – мэдэгдэл болон дотоод журмууд гарсан байна. МН-ЭББ АЖ-ыг батална. Тухайлбал:

- a) МН-ГОБ болон МН-КМОБ-ын үйлчилгээг дэмжиж буй аливаа гадны байгууллагын үүрэг, түүний дотор байх ёстой бодлого, ажиллагааг АЖ-д тодорхойлсон байна.
- b) АЖ-ыг МН-ЭББ, тахографын системийн хэрэглэгч болон хамааралтай бусад талд (ж.нь хяналтын байгууллага) хүртээмжтэй байлгана. Гэхдээ МН-ГОБ/МН-КМОБ өөрийн ажиллагааны талаар нийтлэх, хэрэглэгчид гаргаж өгөхийг шаарддаггүй.
- c) МН-ГОБ/МН-КМОБ -ын удирдлага АЖ-ыг зөв хэрэгжүүлэх үүрэгтэй.
- d) МН-ГОБ/МН-КМОБ нь АЖ-ыг нягтлах үйл явцыг тодорхойлох ёстой.
- e) МН-ГОБ/МН-КМОБ нь АЖ-даа оруулах гэж буй өөрчлөлтийн талаар МН-ЭББ-д зохих ёсоор мэдэгдэх ёстой ба өөрчлөлт батлагдсаны дараа нэмэлт өөрчлөлт оруулсан АЖ-ыг хүртээмжтэй болгоно. Жижиг өөрчлөлтийг МН-ЭББ-аар батлуулалгүй оруулж болно.

5. Төхөөрөмжийн удирдлага

Тахограф системд дараах төхөөрөмжийг хамруулахаар тодорхойлсон:

- Тахографын картууд.
- Тээвэрийн хэрэгсэл
- Хөдөлгөөн мэдрэгч.

Дараах байгууллага төхөөрөмжийг боловсруулж, удирдана:

- МН-КОБ (бүртгэл, сунгалт г.м.)
- МН-ГОБ (гэрчилгээ, хос түлхүүр)
- МН-КМОБ (харагдах болон цахим өгөгдөлийг картад оруулах, буулгах, түгээх (хуваарилах) , идэвхгүй болгох)
- ТХ болон хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгч

МН-ЭББ дараах чиг үүрэгийг гүйцэтгэнэ:

- Чанарын хяналт (төрөлийг зөвшөөрч батлах)

МН-КОБ дараах чиг үүрэгийг гүйцэтгэнэ:

- Карт авах хүсэлтийг хүлээн авах, боловсруулах
- Хүсэлтийг батлах, бүртгэх
- Төхөөрөмжийг бүртгэх болон өгөгдөлийг хадгалах (ӨС)

МН-ГОБ болон МН-КМОБ дараах чиг үүрэгийг гүйцэтгэнэ:

- Чанарын хяналт (жишээг тестлэх, турших)
- Түлхүүр оруулах
- Картад мэдээлэл оруулах, хэвлэн буулгах
- Түгээх (хуваарилах)

ТХ үйлдвэрлэгчийн гүйцэтгэх чиг үүрэг энэ бодлогын хүрээнд хамаарахгүй.

Хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгчийн гүйцэтгэх чиг үүрэг энэ бодлогын хүрээнд хамаарахгүй.

5.1 Тахографын картууд

5.1.1 Чанарын хяналт – МН-ГОБ/МН-КМОБ-ын чиг үүрэг

МН-ГОБ/МН-КМОБ нь зөвхөн дүрмээр зөвшөөрөгдсөн төрөлийн картыг тахограф системд ашиглах, түүнд өгөгдөл оруулахыг баталгаажуулах ёстой. 5.1.7.5-ыг үзнэ үү.

5.1.2 Карт авах хүсэлт гаргах – МН-КОБ-ын чиг үүрэг

МН-КОБ картыг ашиглах нөхцөлийн талаар хэрэглэгчидэд мэдэгдэнэ. Энэ мэдээлэлийг уншаад ойлгодохуйц хэл дээр гаргасан байна.

Мэдээлэлийг хамгийн багадаа монгол болон англи хэл дээр гаргасан байх нь зохистой.

Хэрэглэгч карт авах хүсэлт гаргаж картыг хүлээн авсанаар нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

5.1.2.1 Хэрэглэгч хүсэлт гаргах

Тахографын карт авахаар хүсэлт гаргагч МН-ЭББ юмуу МН-КОБ-аас гаргасан тодорхойлсон маягтын дагуу хүсэлтээ илгээнэ. Хэрэглэгчийг үнэн зөв тодорхойлоход шаардлагатай мэдээлэлийг хүсэлт агуулсан байна.

Карт олгоход дараах мэдээлэл шаардлагатай. Өөр эх сурвалжаас гаргаж аваагүй бол эдгээр мэдээлэлийг хүсэлтэд оруулна:

- Бүтэн овог, нэр
- Төрсөн огноо, газар
- Оршин суух хаяг
- Иргэний үнэмлэх, хувийн адилтгагч дугаар
- Шуудангийн хаяг
- Гэрэл зураг (хүчин төгөлдөр зураг ашиглаагүй бол) (жолоочийн карт биш бол заавал биш)

Жолоочийн картын үзүүлэлт:

- Жолооны үнэмлэхийн дугаар

Засвар үйлчилгээний газарын картын үзүүлэлт:

Засвар үйлчилгээний газарын картыг хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй, дараах нотлох баримтыг гаргаж өгсөн хувь хүнд олгоно:

- Хэрэглэгчийн овог, нэр;
- Төрсөн огноо, газар, үндэс, угсааг илтгэсэн баримт бичигийн ишлэл юмуу ижил нэртэй бусад хүнээс ялгахад ашиглаж болох бусад шинж;
- Хамааралтай хуулийн этгээд юмуу зохион байгуулалтын нэгжийн бүрэн нэр, эрх зүйн статус-төлөв.

Хяналтын картын үзүүлэлт:

Хяналтын картыг хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй, дараах нотлох баримтыг гаргаж өгсөн хувь хүнд олгоно:

- Хэрэглэгчийн овог, нэр;
- Төрсөн огноо, газар, үндэс, угсааг илтгэсэн баримт бичигийн ишлэл юмуу ижил нэртэй бусад хүнээс ялгахад ашиглаж болох бусад шинж;
- Хамааралтай хуулийн этгээд юмуу зохион байгуулалтын нэгжийн бүрэн нэр, эрх зүйн статус-төлөв.

Компанийн картын үзүүлэлт:

Компанийн картыг хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй, тахограф суулгасан тээвэрийн хэрэгсэлийг өмчилдөг, эзэмшдэг, дараах нотлох баримтыг гаргаж өгсөн хувь хүнд олгоно:

- Хэрэглэгчийн овог, нэр;
- Төрсөн огноо, газар, үндэс, угсааг илтгэсэн баримт бичигийн ишлэл юмуу ижил нэртэй бусад хүнээс ялгахад ашиглаж болох бусад шинж;
- Хамааралтай хуулийн этгээд юмуу зохион байгуулалтын нэгжийн бүрэн нэр, эрх зүйн статус-төлөв.
- Хамааралтай хуулийн этгээд юмуу зохион байгуулалтын нэгжийн бүртгэлийн мэдээлэл (ж.нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ);
- Хэрэглэгч тухайн хуулийн этгээд юмуу зохион байгуулалтын нэгжтэй холбогдож буй холбоо, хамаарал.

5.1.2.2 Гэрээ

Хүсэлт гаргагч карт авах хүсэлт гаргаж, картыг хүлээн авахдаа МН-КОБ-тай дараах зүйлсийг илэрхийлж тусгасан гэрээ байгуулна:

- Тахографын картыг ашиглах, боловсруулахтай холбоотой нөхцөлийг хэрэглэгч хүлээн зөвшөөрч байгаа гэдэгийг
- Хэрэглэгч картыг хүлээн авсан мөчөөс эхлэн түүнийг ашиглах бүх хугацаанд МН-КОБ-д ямар нэг мэдэгдэл хүргээгүй бол дараах нөхцөлийг сахин мөрдөх үүрэгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулна:
 - Эрх олгогдоогүй аливаа этгээдэд картад хандах хандалт олгохгүй байх;
 - МН-КОБ-д хэрэглэгчээс гаргаж өгсөн аливаа мэдээлэл үнэн зөв бөгөөд карт дээрх мэдээлэлээс зөрөхгүй байх;
 - Картыг ухамсартайгаар, тавьсан хязгаарлалт, зориулалтын дагуу ашиглах.

5.1.2.3 МН-КОБ-аас батлах нөхцөл – Жолоочийн картын үзүүлэлт

Жолоочийн үнэмлэхийг зөвхөн тухайн хүсэлт гаргаж буй улсад байнга оршин суудаг хүмүүст олгоно. МН-КОБ нь өргөдөл гаргагч өөр улсаас олгосон хүчин төгөлдөр жолоочийн карт эзэмшдэггүй гэдэгийг баталгаажуулна. МН-КОБ нь жолоочийн карт хүсэгч нь зохих ангиллын, хүчинтэй жолооны үнэмлэхтэй байхыг баталгаажуулна

5.1.3 Картыг сунгах –МН-КОБ-ын чиг үүрэг

Засвар үйлчилгээний газарын карт олгосоноос хойш **нэг** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.

Жолоочийн карт олгосоноос хойш **гурван** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.

Компанийн карт олгосоноос хойш **гурван** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.

Хяналтын карт олгосоноос хойш **хоёр** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.

Картын хугацаа дуусаж байгаа тухай мэдэгдэл хүргэх журамыг МН-КОБ тогтооно. Сунгуулах тухай хүсэлт 5.1.2-той нийцсэн байна.

5.1.3.1 Жолоочийн карт

Хэрэглэгч картынхаа хугацаа дуусахаас 15-аас доошгүй хоногийн өмнө картаа сунгуулах хүсэлт гаргана.

Хэрэв хэрэглэгч энэ дүрэмтэй нийцүүлэн хүсэлтээ гаргасан бол МН-КОБ-аас одоогийн картын хугацаа дуусахаас өмнө жолоочийн шинэ карт олгоно.

5.1.3.2 Засвар үйлчилгээний газарын карт

Хэрэглэгч картынхаа хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө картаа сунгуулах хүсэлт гаргана.

МН-КОБ бүрэн дүүрэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор сунгагдсан шинэ карт олгоно.

5.1.3.3 Компанийн карт

Хэрэглэгч картынхаа хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө картаа сунгуулах хүсэлт гаргана.

Хэрэв хэрэглэгч энэ дүрэмтэй нийцүүлэн хүсэлтээ гаргасан бол МН-КОБ-аас одоогийн картын хугацаа дуусахаас өмнө компанийн шинэ карт олгоно.

5.1.3.4 Хяналтын карт

Хэрэглэгч картынхаа хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө картаа сунгуулах хүсэлт гаргана.

МН-КОБ бүрэн дүүрэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор сунгагдсан шинэ карт олгоно.

5.1.4 Картыг шинэчлэх юмуу солих – МН-КОБ-ын чиг үүрэг

Оршин сууж буй улсаа сольж буй хэрэглэгч өөрийн жолоочийн картыг солих хүсэлт гаргаж болно.

Түүний карт хүчинтэй байгаа бол хэрэглэгч зөвхөн оршин суугаа газараа баталгаажуулснаар хүсэлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

МН-КОБ шинэ картыг илгээсэний дараа өмнөх картыг хураан авч анх олгосон улсын ЭББ-д илгээнэ.

Бусад тохиолдолд оршин суугаа улсаа сольсонтой холбоотойгоор жолоочийн карт солих ажиллагааг шинэ карт олгох дүрэмээр зохицуулна.

5.1.5 Хаясан, хулгайлагдсан, гэмтсэн, ажиллахгүй картыг солих – МН-КОБ-ын чиг үүрэг

Хэрэглэгч картаа хаясан, хулгайд алдсан бол энэ тухайгаа цагдаагийн газарт мэдэгдэж энэ тухайгаа бүртгэлийн хувь, цагдаагийн бичиг авна. Олдсон картыг хүлээн авах үедээ хэрэглэгч юмуу цагдаагийн газар картыг хаясан тухай мэдэгдэж болно. Цагдаагийн газар карт хаясан тухай бүртгэж авсан, бичиг олгосон талаараа МН-КОБ-д нэн даруй мэдэгдэнэ.

Хулгайлагдсаг юмуу хаягсан картыг ЕХ-ны гишүүн улсууд болон хэлэлцээрт нэгдэн орсон улсуудын ЭББ-ын хандах боломжтой хар жагсаалтад оруулна. TachoNet -д өгөгдөл оруулсанаар хар жагсаалт ЕХ-ны гишүүн улсууд болон хэлэлцээрт нэгдэн орсон улсуудад хүртээмжтэй болно.

Гэмтсэн, ажиллахгүй байгаа картыг МН-КОБ-д илгээж хүчингүй болгож хар жагсаалтад оруулна.

Хэрэв картаа хаясан, хулгайд алдсан, гэмтсэн, ажиллахгүй байгаа бол хэрэглэгч түүнийг солиулах хүсэлтийг 7 хоногийн дотор гаргана.

Хэрэв хэрэглэгч дээрх шаардлагыг сахин мөрдөж хүсэлт гаргасан бол МН-КОБ шинэ түлхүүр, гэрчилгээ бүхий шинэ картыг хүсэлт хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор олгоно.

Сольсон картын хугацааг шинээр тооцохгүй бөгөөд өмнө картын үлдсэн хугацаанаас үргэлжилнэ. (Дүрэмийн хавсралт 1В: VII). Хэрэв сольж картын хугацаа 6 сараас доош байвал МН-КОБ шинэ карт олгож болно.

5.1.6 Хүсэлтийн зөвшөөрөлийг бүртгэх – МН-КОБ-ын чиг үүрэг

МН-КОБ зөвшөөрөгдсөн хүсэлтийг өгөгдөлийн санд бүртгэх ёстой. Энэ өгөгдөл нь гэрчилгээ үүсгэх болон картад мэдээлэл оруулах үед уг мэдээлэлийг ашигладаг МН-ГОВ/МН-КМОБ-д хүртээмжтэй байна.

5.1.7 Картад мэдээлэл оруулах – МН-КМОБ-ын чиг үүрэг

Картын мэдээлэлийг ил харагдах болон цахим хэлбэрээр оруулна. Ихэнх тохиолдолд картад мэдээлэл оруулах ажлыг үйлчилгээ үзүүлэгч байгууллага гүйцэтгэдэг ч энэ нь МН-ЭББ-ын нийтлэг үүрэг, хариуцлагыг бууруулахгүй.

5.1.7.1 Харагдах мэдээлэлийг оруулах

Картын гадарга дээр харагдах мэдээлэлийг Дүрэмийн хавсралтын 1В, бүлэг IV-т заасаны дагуу хэвлэж оруулна.

5.1.7.2 Хэрэглэгчийн өгөгдөлийг оруулах

Картын санах ойд оруулах өгөгдөлийг картын төрөлөөс хамааран Дүрэмийн хавсралтын 1В, хавсралт 2, TCS_403, TCS_408, TCS_413 болон TCS_418 дүрэмд заасан бүтэцийн дагуу оруулна. IV-т заасаны дагуу Data shall be inserted in the card according to the structure in Regulation Annex 1B, appendix 2, rules TCS_403, TCS_408, TCS_413 and TCS_418, depending on card type.

5.1.7.3 Түлхүүр оруулах

Хувийн түлхүүрийг үүсгэсэн орчиноос нь гаргалгүйгээр картад оруулна. Энэ орчин нь аливаа этгээд, ямар нэг байдлаар, өөрөө илрэхгүйгээр, үүсгэсэн хувийн түлхүүрийг удирдах, хянах боломжгүй байдалыг хангах ёстой. Түүнчлэн төхөөрөмжийн түлхүүрийн удирдлага 7.2-ыг үзнэ үү.

5.1.7.4 Гэрчилгээ оруулах

Картыг хэрэглэгчид хүргэхээс өмнө хэрэглэгчийн гэрчилгээг картад оруулсан байх ёстой.

5.1.7.5 Чанарын хяналт

Хэрэглэгчийн карт дээрх мэдээлэл, санах ойд оруулсан мэдээлэл болон гэрчилгээ хоорондоо болон эзэмшигчтэй нийцэж байхыг баталгаажуулах баримтжуулсан дэг, журам гаргасан байх ёстой. Энэ дэгийг картад мэдээлэл оруулах АЖ-д тодорхойлсон байна.

5.1.7.6 Түгээгдээгүй, хүргэгдээгүй картуудыг хүчингүй болгох (устгах)

Мэдээлэл оруулах үед гэмтсэн, эвдэрсэн (өөр ямар нэг шалтгаанаар дуусгаж, түгээж чадаагүй) бүх картыг биетээр болон цахим хэлбэрээ бүрэн устгана (хүчингүй болгоно).

Устгасан бүх картыг цаасан дээр бүртгэнэ. Карт устгах ажиллагаанд доод зах нь хоёр хүн оролцож хянаж гарын үсэг зурна.

5.1.8 Картыг бүртгэх болон өгөгдөлийг (ӨС) хадгалах – МН-КМОБ болон МН-КОБ-ын чиг үүрэг

Аль хэрэглэгчид ямар карт болон картын дугаар олгогдсоныг бүртгэх, мөшгөх үүрэгийг МН-КМОБ хүлээнэ. Картад мэдээлэл оруулсанаас хойш 2 сарын хугацаанд энэ мэдээлэлийг МН-КМОБ-оос үзэх боломжтой байна. Энэ хугацаа өнгөрсөний дараа өгөгдөлийг МН-КМОБ-аас МН-КОБ-ын бүртгэлд шилжүүлнэ.

5.1.9 Картыг хэрэглэгчид түгээх (хуваарилах) – МН-КМОБ юмуу МН-КОБ-ын чиг үүрэг

- a) Мэдээлэл оруулсан картыг хэрэглэгчид хүргэхийн өмнө хадгалах хугацааг хамгийн бага байхаар мэдээлэл оруулах ажиллагааг төлөвлөнө. Картыг шөнийн цагаар (хэд хэдэн хоног хадгалах бол) найдвартай хадгалах ёстой. Үйлдвэрлэлийн үйл явцад тасалдал үүсэх, хүргэх, түгээх (хуваарилах) эд саатал гарах, картыг алдах, гэмтээх гэх мэт онцгой тохиолдолд юу хийхийг тодорхойлсон баримтжуулсан журам гаргасан байх ёстой.
- b) Мэдээлэл оруулсан картыг хүргэлт, түгээлт хийх газарт, ө.х хяналттай бүсэд нэн даруй хүргэнэ,.
- c) Мэдээлэл оруулсан картыг мэдээлэлгүй карт, картын бэлдэцээс тусгаарлан хадгалах ёстой.
- d) Алдагдах эрсдэлийг хамгийн бага болгосон байдалаар тахографын картыг түгээх (хуваарилах) ёстой.
- e) Картыг хүлээлгэн өгөх үед хэрэглэгчийн хувийн мэдээлэлийг (ж.нь овог, нэр) тухайн хувь хүнтэй харьцуулан шалгах ёстой.
- f) Хэрэглэгч өөрийг нь адилтган таних, хүчин төгөлдөр баримт бичиг, зүйлийг гарган үзүүлэх ёстой.
- g) Карт хүлээн авсаныг хэрэглэгчийн гарын үсэгээр баталгаажуулна.

5.1.10 Таньж баталгаажуулах код (ПИН) – МН-КМОБ-аас үүсгэнэ.

Энэ заалт нь зөвхөн засвар үйлчилгээний картад хамааралтай.

Засвар үйлчилгээний газарын карт тээвэрийн хэрэгсэлтэй ажиллах үед таньж баталгаажуулахад ашиглагддаг ПИН кодтой байна. (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 10: Тахографын картууд: 4.2.2)

ПИН код хамгийн багадаа 4 тэмдэгтээс бүрдэнэ (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 10: Тээвэрийн хэрэгсэл: 4.1.2).

5.1.10.1 ПИН үүсгэх

ПИН кодыг хамгаалагдсан системд үүсгэж, хамгаалагдсан байдалаар засвар үйлчилгээний газарын картад шилжүүлж (оруулж) ПИН дугтуй дээр шууд хэвлэнэ. ПИН код болон хэрэглэгчийн хооронд холбоо тогтох боломжтойгоор компьютер дээр хадгалахыг хориглоно. ПИН үүсгэх систем нь ITSEC E3, CC EAL4 юмуу түүнтэй дүйцэх аюулгүй байдалын шалгуурыг хангасан байна.

5.1.10.2 ПИН-ыг хүргэх

ПИН кодыг ердийн шуудангаар хүргэж болно.

ПИН кодыг хамааралтай картын хамт хүргүүлэхийг хориглоно.

5.1.11 Картыг идэвхгүй болгох – МН-ЭББ/МН-КОБ болон МН-КМОБ-ын чиг үүрэг

Карт болон түүнд оруулсан түлхүүрийг идэвхгүй болгох боломжтой байх ёстой. Идэвхгүй болгох шийдвэрийг МН-ЭББ юмуу МН-КОБ гаргах ба ажиллагааг МН-КМОБ юмуу үйлчилгээ үзүүлэгч байгууллага гүйцэтгэнэ.

Картыг идэвхгүй болгох ажиллагааг зориулалтын төхөөрөмж дээр гүйцэтгэх ба дараа нь картын чиг үүрэг, түлхүүр устгагдсан гэдэгийг шалгах ёстой. Мөн картыг харагдах байдалаар нь хүчингүй болгоно.

Идэвхгүй болгосон картыг МН-КМОБ-ын картын өгөгдөлийн санд бүртгэж дугаарыг нь хар жагсаалтад оруулна.

5.2 Тээвэрийн хэрэгсэл болон хөдөлгөөн мэдрэгч

Одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй.

6. Суурь түлхүүрүүд болон дамжуулалтын түлхүүрийн удирдлага: Европын суурь түлхүүр, Монгол Улсын түлхүүр, хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүр, дамжуулалтын түлхүүр

Энэ хэсэг нь дараах түлхүүрийн удирдлагын тухай заалтыг агуулна:

- Европын Суурь түлхүүр – ЕСГБ-ERCA-ийн нийтийн түлхүүр (ЕВР.НТ)
- Монголын хос түлхүүр, ж.нь. Монголын гарын үсэг зурах хос түлхүүр (МН.ХТ, МН-НТ)
- Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд (Kmwc)
- Дамжуулалтын түлхүүрүүд (ЕСГБ болон МН-ГОБ-ын хооронд холбогдоход ашиглах)

ЕСГБ-ын нийтийн түлхүүр нь Монголын гэрчилгээг баталгаажуулахад ашиглагдана. ЕСГБ-ын хувийн түлхүүр хэзээ ч тэндээс гадагш гарахгүй учир энд ашиглахгүй.

Монголын хос түлхүүр (хувийн нууц түлхүүр болон нийтийн түлхүүр) нь Монгол Улсын гарын үсэг зурах түлхүүрүүд (мөн Монголын суурь түлхүүрүүд гэж нэрлэгдэнэ) болно.

Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд нь засвар үйлчилгээний газарын карт болон ТХ болон хөдөлгөөн мэдрэгчид байршуулдаг, харилцан таних зориулалттай тэгш хэмтэй (симметрик) түлхүүрүүд болно. МН-ГОБ хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг ЕСГБ-аас аваад хадгалж дараа нь үйлдвэрлэгч, нийлүүлэгчид түгээнэ.

Дамжуулалтын түлхүүрүүд нь ЕСГБ болон МН-ГОБ-ын хооронд мэдээлэлийг аюулгүй дамжуулах, солилцоход ашиглах тэгш бус хэмтэй (асимметрик) түлхүүрүүд болно.

Хэрэв МН-ГОБ дээр дурдсанаас өөр криптографын түлхүүр хэрэглэвэл тахографын системийн хэсэг гэж тооцогдохгүй бөгөөд энэ бодлогод хамаарахгүй.

МН-ГОБ өөрийн системийн (домэйн) хүрээнд үүсгэгдсэн, ашиглагдаж байгаа юмуу хадгалагдаж буй хувийн түлхүүрийн нууцлал, бүрэн бүтэн байдалыг хангаж, тэдгээр түлхүүрийг хууль бусаар ашиглах аливаа оролдлогоос сэргийлнэ. Энэ зорилгоор дараах шаардлагуудын аль нэгийг хангасан техникийн системийг нэвтрүүлсэн байна:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 эсхүл дээш [FIPS],
- CEN/TS 419261 (Гэрчилгээ болон цагийн тэмдэглэгээгээр удирдагдаж буй итгэлтэй системд тавигдах аюулгүй байдалын шаардлага) [CEN],
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл

юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиг гэрчилгээ авсан,

- Аюулгүй байдалын дүцэхүйц түвшинг хангаж буй аюулгүй байдалын шаардлага.

Энэ байдлаар МН-ГОб-ын хамгаалагдсан орчинд энэ систем ажиллаж байгаа гэдгийг баталгаажуулна. Хамгаалагдсан орчиноос гадуур хувийн түлхүүрийн хувь байх ёсгүй. МН-ГОб нь Монголын хувийн түлхүүрийг хадгалахад ашиглаж буй төхөөрөмж дээр төхөөрөмжийн гэрчилгээний гарын үсгийг зурна.

6.1 ЕСГБ-ын нийтийн түлхүүр

МН-ГОб ЕСГБ-ын нийтийн түлхүүрийг (ЕВР-НТ) хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байдлаар хадгалах ёстой. ЕСГБ-ын ЕВР.НТ-ийг МН-КМОБ-д хадгалж байгаа үед нэгэн адил дүрэмийг баримтална.

МН-КМОБ өөрийн хариуцаж буй бүх карт болон ТХ-д ЕВР-НТ орсон гэдгийг баталгаажуулах ёстой.

6.2 Монголын хос түлхүүр

Монголын түлхүүрүүд нь МН-ГОб-ын гарын үсэг зурдаг хос түлхүүр байх бөгөөд бүх төхөөрөмжийн гэрчилгээнд гарын үсэг зурахад ашиглагдана. Хоёр түлхүүр нь нийтийн түлхүүр (МН-НТ) болон хувийн, нууц түлхүүрээс (МН-ХТ) бүрдэнэ. МН-ГОб-ын нийтийн түлхүүрийг ЕСГБ гэрчилгээжүүлэх ёстой, гэхдээ МН-ГОб өөрөө үүсгэсэн байна.

Монголын хувийн түлхүүрийг тахографын гэрчилгээнд гарын үсэг зурах, ЕСГБ-ын түлхүүр гэрчилгээжүүлэх хүсэлт (ТГХ- КСР) үүсгэхээс бусад зорилгоор ашиглаж болохгүй.

6.2.1 Монголын түлхүүрүүдийг үүсгэх

Монголын хос түлхүүрийг дараах шаардлага хангасан төхөөрөмж дотор үүсгэнэ:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл
- CEN/TS 419261 (Гэрчилгээ болон цагийн тэмдэглэгээгээр удирдагдаж буй итгэлтэй системд тавигдах аюулгүй байдалын шаардлага) [CEN] хангасан,
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиг гэрчилгээ авсан итгэлтэй систем,

Түлхүүр үүсгэх төхөөрөмж нь бие даасан байна.

Ашиглаж байгаа, шаардлага хангасан төхөөрөмжийг МН-ГОб-ын АЖ-д тодорхойлогдсон байна.

МН-ГОб-ын хос түлхүүр үүсгэхэд 3-аас доошгүй хүн идэвхтэй оролцоно. Тэдний нэг нь ГОб/МОА (Гэрчилгээ олгох байгууллага/мэдээлэл оруулах администратор) -ын чиг үүрэг гүйцэтгэх бөгөөд бусад нь итгэмжлэгдсэн үүрэг роль гүйцэтгэнэ. (9.3.1 үүрэг ролийн тодорхойлолтыг үзнэ үү).

$n=1024$ битийн урттай түлхүүр бүхий RSA алгоритм ашиглан түлхүүрүүдийг үүсгэх ёстой. (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 11:2.1/3.2).

ЕСГБ Монголын гэрчилгээг хурдан хугацаанд сольж олгох боломжгүй учир тасралтгүй ажиллагааг хангах үүднээс МН-ГОб хамгийн багадаа хоёр (2), хамгийн ихдээ таван (5) хос

түлхүүр, хамаарах гэрчилгээтэй байна.

6.2.2 Монголын түлхүүрүүдийн хүчинтэй хугацаа

МН-ГОб-ын хувийн түлхүүр бүр хамаарах нийтийн түлхүүрийн гэрчилгээ олгосон мөчөөс эхлэн 2 жилийн хугацаатай байх бөгөөд хугацаа нь дууссан хойно ямар нэг зорилгоор ашиглаж болохгүй.

Хамаарах нийтийн түлхүүр нь хугацаагүй үйлчилнэ.

6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт

Эвдлэхээс тусгайлан хамгаалсан, дараах шаардлага хангасан төхөөрөмжид хувийн түлхүүрийг хадгалж, ажиллуулна:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем.

МН-ГОб-ын хувийн түлхүүрт хандахад давхар хяналт шаардагдана. Энэ нь хувийн түлхүүр хадгалсан орчинд хандах хэрэгсэлийг нэг хүн эзэмшиж болохгүй гэсэн утгатай. Энэ нь төхөөрөмжийн гэрчилгээнд гарын үсэг зурахад давхар хяналттай байна гэсэн утгыг агуулаагүй.

6.2.4 Монголын хувийн түлхүүрийн нөөц хуулбар

Монголын хувийн түлхүүрүүдийг давхар хяналттай түлхүүрийг сэргээх журам ашиглан нөөцлөн хуулбарлах боломжтой. Үүнд ашиглаж буй журамыг МН-ГОб-ын АЖ-д тодорхойлсон байна.

6.2.5 Монголын хувийн түлхүүрийг хадгалуулах

Монголын хувийн түлхүүрийг бусдад хадгалуулахгүй.

6.2.6 Монголын түлхүүрүүд эрсдэлд орох

Монголын хувийн түлхүүр задарсан, эсхүл ямар нэг байдлаар эрсдэлд орсон сэжиг илэрвэл хэрэглэгч, МН-ГОб-ын аюулгүй байдал хариуцсан ажилтан болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага хийх ёстой ажиллагааг тодорхойлсон бичгэн заавар байх ёстой бөгөөд МН-ГОб-ын АЖ-д орсон байна.

Энэ тохиолдолд МН-ГОб хамгийн багадаа:

- Нэн даруй МН-ЭББ, ЕСГБ болон хэлэлцээрийн оролцогч бусад талд мэдэгдэх ёстой.

6.2.7 Монголын түлхүүрүүд дуусгавар болох

МН-ГОб гарын үсэг зурах хүчин төгөлдөр, гэрчилгээжсэн хос түлхүүртэй байгааг баталгаажуулах журамтай байна.

Монголын хос түлхүүрийн ашиглах хугацаа дуусахаас өмнө МН-ГОб нийтийн түлхүүрийг архивлан хадгалж хувийн түлхүүрийг дахин ашиглах, сэргээх боломжгүйгээр устгана.

6.3 Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд

МН-ГОб хөдөлгөөн мэдрэгчийн K_{mwc} түлхүүрийг ЕСГБ-аас хүсэх ёстой. (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 11:3.1.3). МН-ГОб хөдөлгөөн мэдрэгчийн мастер түлхүүр K_m юмуу Тээвэрийн хэрэгсэлийн хөдөлгөөн мэдрэгчийн K_{m_{vu}} түлхүүрийг боловсруулж, удирдаж

болохгүй.

МН-ГОБ зөвхөн засвар үйлчилгээний газарын түлхүүрийг МН-КМОБ-д дамжуулан илгээнэ. Энэ түлхүүрийг засвар үйлчилгээний газарын картад оруулна. МН-ГОБ зохих арга хэмжээ хэрэгжүүлэх замаар Кmwc түлхүүр зохих хүлээн авагчид очсон гэдэгийг баталгаажуулж хамгаалагдсан замаар түүнийг дамжуулан илгээнэ.

МН-КМОБ -аас МН-ГОБ-ын чиг үүрэгийг төлөөлөн гүйцэтгэж Кmwc мастер түлхүүрийг засвар үйлчилгээний газарын картад оруулна. (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 11:3.1.3).

МН-ГОБ болон МН-КМОБ хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүдийг хадгалах, ашиглах, түгээх (хуваарилах) үедээ аюулгүй байдалын биет болон логик арга хэмжээ ашиглан хамгаална. Эвдлэхээс хамгаалсан, дараах шаардлага хангасан төхөөрөмж дээр түлхүүрүүдийг хадгалж, ажиллуулна:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем.

6.4 Дамжуулалтын түлхүүрүүд

Өгөгдөлийг аюулгүй дамжуулахын тулд МН-ГОБ тусгай, тэгш бус хэмтэй дамжуулалтын түлхүүр үүсгэх ёстой. МН-ГОБ эдгээр түлхүүрийг үүсгэх, хадгалах, ашиглах, түгээх (хуваарилах) үедээ аюулгүй байдалын биет болон логик арга хэмжээ ашиглан хамгаална. Эвдлэхээс хамгаалсан, дараах шаардлага хангасан төхөөрөмж дээр Түлхүүрүүдийг хадгалж, ажиллуулна:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем

6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх (хуваарилах) хүсэлт

МН-ГОБ болон ЕСГБ-ын хооронд түлхүүр дамжуулахдаа ЕСГБ-ын Суурь бодлогоор тодорхойлсон хэрэгсэл, тээгч, протоколыг ашиглана. МН-ЭББ-аас МН-ГОБ болон ЕСГБ-ын хооронд дамжуулж буй мэдээлэлийг агуулсан тээгчийг дамжуулан өгөх эрх бүхий этгээдийг томилно.

МН-ГОБ Дижитал тахограф системийн талаар Европын Суурь Бодлогын (ЕСГБ) Хавсралт А-д тодорхойлсон түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт (ТГХ)-ийн протоколыг ашиглан өөрийн нийтийн түлхүүрийг (МН-НТ) гэрчилгээжүүлэхээр ЕСГБ-д хүргүүлнэ.

МН-ГОБ ЕСГБ-ын нийтийн түлхүүрийг (ЕВР-НТ) Дижитал тахограф системийн талаар Европын Суурь Бодлогын (ЕСГБ) Хавсралт В-д тодорхойлсон түгээх (хуваарилах) форматын дагуу таньж зөвшөөрнө.

МН-ГОБ Дижитал тахограф системийн талаар Европын Суурь Бодлогын (ЕСГБ) Хавсралт D-д тодорхойлсон түлхүүрийг түгээх (хуваарилах) хүсэлт (ТТХ)-ийн протокол ашиглан хөдөлгөөн

мэдрэгчийн мастер түлхүүрийг ЕСГБ-аас хүснэ.

МН-ГОБ болон МН-КМОБ-аас ЕСГБ-д гэрчилгээжүүлэхээр болон хөдөлгөөн мэдрэгчид суулгахаар хүргүүлсэн Түлхүүрийн Адилтгагч (ТА) болон түлхүүрийн (n) модуль нь МН-ГОБ болон МН-КМОБ-ын орчинд (домэйн) хосгүй байхыг баталгаажуулна.

Хувийн түлхүүр HSM төхөөрөмжид үлдэж, түлхүүрийг гэрчилгээжүүлэх үед дамжуулагдахгүй гэдгийг МН-ГОБ баталгаажуулна.

Дамжуулалтын хувийн түлхүүр HSM төхөөрөмжид үлдэж, тэгш хэмт түлхүүрийг түгээх (хуваарилах) үед дамжуулагдахгүй гэдгийг МН-ГОБ баталгаажуулна.

7. Төхөөрөмжийн түлхүүрүүд (тэгш бус)

Төхөөрөмжийн түлхүүрүүд нь тахографын систем дахь дараах төхөөрөмжид зориулан олгох, үйлдвэрлэх үйл явцад үүсгэдсэн, МН-ГОБ-аас гэрчилгээжүүлсэн тэгш бус хэмтэй түлхүүрүүд юм.:

- Тахографын картууд.
- Тээврийн хэрэгсэл (одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй). Хөдөлгөөн мэдрэгчийн тэгш хэмт түлхүүрийг энд авч үзэхгүй.

7.1 МН-ГОБ/МН-КМОБ, түүний дотор үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон ТХ үйлдвэрлэгчийн нийтлэг асуудал

Төхөөрөмжийг (Карт болон ТХ) идэвхжүүлэх, түлхүүрийг ачаалж оруулах, мэдээлэл оруулах ажиллагааг биет хамгаалалттай, хяналттай орчинд гүйцэтгэнэ.

Энэ орчинд биетээр хандахыг хатуу зохицуулж нэг бүрчлэн хянах ба системийг ажиллуулахад доод зах нь 2 хүн байлцана. Системд өгөгдөл оруулсан, түүнтэй ажилласан бүртгэлийг бүртгэж байна.

Түлхүүр үүсгэх системд агуулагдаж буй нууц, чухал мэдээлэлийг энэ бодлогыг зөрчсөн замаар системээс гадагш гаргахыг хатуу хориглоно.

Тахографын карт: Картад мэдээлэл оруулах систем дахь нууц мэдээлэлийг энэ бодлогыг зөрчсөн замаар системээс гадагш гаргахыг хатуу хориглоно.

ТХ/Хөдөлгөөн мэдрэгч: (одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага. Монголын эрх бүхий аль нэг байгууллагын нэрийн өмнөөс түлхүүр үүсгэх, картад мэдээлэл оруулах ажиллагааг гүйцэтгэж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллага эдгээр ажиллагааг тус тусдаа үйл явцаар гүйцэтгэнэ. Үйл явц (процесс) бүрт бүртгэл-лог хөтлөх бөгөөд холбогдох эрх бүхий байгууллага хүсэлт тавьж түүнд нэвтрэх эрхтэй байна.

ТХ үйлдвэрлэгч. (одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

МН-ГОБ/МН-КМОБ/Үйлчилгээ үзүүлэгч/ТХ үйлдвэрлэгч: Картад мэдээлэл оруулах системийн лог бүртгэл нь захиалгын тухай мэдээлэл болон хамааралтай төхөөрөмжийн дугаар болон гэрчилгээний жагсаалтыг агуулсан байна. Хамааралтай эрх бүхий байгууллага хүсэлт тавьж түүнд нэвтрэх эрхтэй байна. МН-КМОБ-ын өгөгдөлийн санд тухайн лог бүртгэлийн өгөгдөлийг 2 сар хадгална.

7.2 Төхөөрөмжийн түлхүүр үүсгэх

Төхөөрөмжийн түлхүүрүүдийг үйлдвэрлэгч юмуу МН-КМОБ үүсгэж болно (Хавсралт 1В, хавсралт 11:3.1.1)

Төхөөрөмжийн түлхүүрүүд аюулгүй байдлаар үүсгэгдсэн, хувийн түлхүүрийг аюулгүй хадгалсан гэдэгийг МН-КМОБ баталгаажуулна.

Түлхүүрүүдийг дараах шаардлага хангасан төхөөрөмж дээр үүсгэнэ:

- FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл
- CEN/TS 419261 (Гэрчилгээ болон цагийн тэмдэглэгээгээр удирдагдаж буй итгэлтэй системд тавигдах аюулгүй байдалын шаардлага) [CEN] хангасан,
- Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем,

$n=1024$ битийн урттай түлхүүр бүхий RSA алгоритм ашиглан түлхүүрүүдийг үүсгэх ёстой. (Дүрэмийн хавсралт 1В, хавсралт 11:2.1/3.2).

Хувийн түлхүүр үүсгэх, хадгалах журам, үйл явц нь түүнийг үүсгэсэн системээс гадагш задлахаас бүрэн сэргийлсэн байна. Түүнчлэн түлхүүрийг төхөөрөмжид оруулсаны дараа заавал устгана.

Түлхүүр үүсгэж буй байгууллага нийтийн түлхүүрийг гэрчилгээтэй холбож өгөх хүртэл түүний хосгүй шинжийг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх үүрэгтэй. (Түлхүүр үүсгэх систем үл давтагдах зарчимаар ажилладаг, тиймээс давхардсан түлхүүр үүсэх магадлал байхгүй байдлаар үүнийг зохион байгуулдаг). Төхөөрөмжийн картын нийтийн түлхүүрийн хосгүй шинжийг МН-ГОБ шалган баталгаажуулах ба түлхүүр давхардсан бол гэрчилгээг хүчингүй болгоно.

7.2.1 Түлхүүрийг багцаар үүсгэх

Криптографийн түлхүүр үүсгэх ажиллагааг гэрчилгээний хүсэлт гарахын өмнө юмуу хүсэлт гаргасантай холбогдуулан багцаар нь гүйцэтгэж болно.

Багцаар үүсгэх ажиллагааг дээр дурдсан шаардлага хангасан бие даасан төхөөрөмж дээр гүйцэтгэнэ. Гэрчилгээ олгох ажиллагаа дуустал түлхүүрийн бүрэн бүтэн байдалыг хамгаална.

7.2.2 Төхөөрөмжийн түлхүүрийн хүчинтэй хугацаа

7.2.2.1 Карт дээрх түлхүүрүүд

Энэ бодлогын дагуу олгосон гэрчилгээтэй хамааралтай хувийн түлхүүрийн ашиглалтын хугацаа гэрчилгээний хүчинтэй хугацаанаас илүү байж болохгүй.

7.2.2.2 Тээвэрийн хэрэгсэл

(одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

7.2.3 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хамгаалах болон хадгалах - Картууд

МН-ГОБ хувийн түлхүүр бүрэн хамгаалагдсан, энэ бодлогод тусгасан журамын дагуу хэрэглэгчид хүргүүлсэн карт дотор байгаа гэдэгийг баталгаажуулна.

Хувийн түлхүүрийн хувийг түлхүүр үүсгэх, мэдээлэл оруулах үед шаардагдахгүй бол тахографын картаас өөр хаана ч хадгалж болохгүй.

Ямар ч тохиолдолд хувийн түлхүүрийг картаас гаргаж, гадна хадгалж болохгүй.

7.2.4 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хамгаалах болон хадгалах – ТХ

(одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

7.2.5 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хадгалуулах болон архивлах

Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг бусдад хадгалуулах юмуу архивлаж болохгүй.

7.2.6 Төхөөрөмжийн нийтийн түлхүүрийг архивлах

Гэрчилгээ олгогдсон бүх нийтийн түлхүүрийг МН-ГОВ архивлан хадгална. Гэрчилгээ олгогдсон нийтийн түлхүүрийн талаар мэдээлэлийг МН-КМОВ хадгалж болно.

7.2.7 Төхөөрөмжийн түлхүүрүүд дуусгавар болох

Тахографын картыг ашиглаж дууссан бол нийтийн түлхүүрийг архивлаж хувийн түлхүүрийг дараах байдалаар боловсруулна:

- Дахин сэргэх боломжгүйгээр устгах; эсхүл
- Дахин ашиглах боломжгүй байдлаар хамгаалж хадгалах.

Тээврийн хэрэгсэлийг ашиглахгүй болсон бол нийтийн түлхүүрийг архивлаж хувийн түлхүүрийг дараах байдалаар боловсруулна:

- Дахин сэргэх боломжгүйгээр устгах; эсхүл
- Дахин ашиглах боломжгүй байдлаар хамгаалж хадгалах.

8. Төхөөрөмжийн гэрчилгээний удирдлага

Энэ хэсэгт гэрчилгээг бүртгэх чиг үүрэг, гэрчилгээг олгох, түгээх, ашиглах, сунгах, хүчингүй болгох, дуусгавар болгох зэргийг хамарсан ашиглалтын мөчлөгийг тодорхойлсон.

8.1 Өгөгдөл оруулах

8.1.1 Тахографын карт

Карт эзэмшигч гэрчилгээ авах хүсэлт гаргахгүй. МН-КОВ-ын бүртгэлийн сангаас гаргаж авсан тахографын карт авах хүсэлтийн мэдээлэл дээр суурилан гэрчилгээг олгоно. (5.1.2) Гэрчилгээжиж буй нийтийн түлхүүрийн түлхүүр үүсгэх ажиллагаанаас гаргаж авна.

МН-КМОВ оруулж буй өгөгдөл нь гэрчилгээ эзэмшигчийг илэрхийлсэн ишлэлийг хосгүй болгож буй мэдээлэл агуулж байгааг баталгаажуулна. МН-ГОВ өөрийн домейнд гэрчилгээ эзэмшигчийн хосгүй байдалыг шалгаж байна.

Гэрчилгээ хүсэх үйл явц гэрчилгээжүүлэх гэж буй нийтийн түлхүүртэй хаамаралтай хувийн түлхүүрийг МН-КМОВ эзэмшиж байгаа гэдэгийг баталгаажуулж байна. Энэ үед хувийн түлхүүр нь түүнийг үүсгэсэн, хамгаалагдсан орчиноос гадагш гарах ёсгүй.

8.1.2 Тээврийн хэрэгсэл

(одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

8.2 Тахографын картын гэрчилгээнүүд

8.2.1 Жолоочийн гэрчилгээ

Жолоочийн гэрчилгээг жолоочийн карт авах хүсэлт гаргаж шалгарсан хүнд олгоно.

8.2.2 Засвар үйлчилгээний газарын гэрчилгээнүүд

Засвар үйлчилгээний газарын гэрчилгээг засвар үйлчилгээний газарын карт авах хүсэлт гаргаж шалгарсан этгээдэд олгоно.

8.2.3 Хяналтын гэрчилгээнүүд

Хяналтын гэрчилгээг хяналтын карт авах хүсэлт гаргаж шалгарсан этгээдэд олгоно.

8.2.4 Компаний гэрчилгээ

Компаний гэрчилгээг компаний карт авах хүсэлт гаргаж шалгарсан этгээдэд олгоно.

8.3 Тээврийн хэрэгсэлийн гэрчилгээ

(одоогоор болон ойрын ирээдүйд Монгол Улсад хамаарахгүй).

8.4 Төхөөрөмжийн гэрчилгээний хүчинтэй хугацаа

Төхөөрөмжийн гэрчилгээ нь хамааралтай төхөөрөмжийн ашиглалтын хугацаанаас их байж болохгүй (бүлэг 5):

- Жолоочийн карт олгосоноос хойш **гурван** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.
- Засвар үйлчилгээний газарын карт олгосоноос хойш **нэг** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.
- Хяналтын карт олгосоноос хойш **хоёр** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.
- Компанийн карт олгосоноос хойш **гурван** жилээс дээшгүй хугацаанд хүчинтэй.

8.5 Төхөөрөмжийн гэрчилгээ олгох

МН-ГОВ өөрийн олгож буй гэрчилгээний үнэн зөв, бүрэн бүтэн байдалыг хангаж байгаа гэдэгийг баталгаажуулна. Гэрчилгээний агуулга нь Дүрэмийн Хавсралт 1В, хавсралт 11-тай нийцсэн байна.

8.6 Төхөөрөмжийн гэрчилгээг сунгах, шинэчлэх

Бүлэг 5-д дурдсан төхөөрөмжийн удирдлага хэсгийг үзнэ үү. Гэрчилгээ болон карт нь адилхан хүчинтэй хугацаатай учир хамтад нь авч үзнэ. ТХ-ийн гэрчилгээ хугацаагүй юмуу их урт хугацаатай байдаг, төхөөрөмжийн ашиглалтын хугацаа гэрчилгээний хугацаанаас бага гэдэг үүднээс авч үздэг.

8.7 Төхөөрөмжийн гэрчилгээ болон мэдээлэлийг тараах

Гэрчилгээ, төхөөрөмж болон хэрэглэгчид холбогдсон байхын тулд МН-ГОВ бүх гэрчилгээг МН-КОБ-ын бүртгэлийн санд экспортолж оруулна.

Хэрэглэгч болон хамааралтай талуудын хэрэгцээтэй үед нь гэрчилгээ хүртээмжтэй байхыг МН-КОБ баталгаажуулна.

Бүх нөхцөл, МН-ГОВ-ын АЖ-ын хамааралтай хэсгүүд болон бусад хамааралтай мэдээлэл бүх хэрэглэгч, хамаарах тал болон бусад хамааралтай бүлэгүүдэд хүртээмжтэй байхыг МН-КОБ баталгаажуулна.

МН-ГОВ гэрчилгээний төлөвийн талаар мэдээлэлийг хөтөлж, хүртээмжтэй болгоно.

8.8 Төхөөрөмжийн гэрчилгээний ашиглалт

Тахографын гэрчилгээ зөвхөн тахографын системд ашиглагдана.

8.9 Төхөөрөмжийн гэрчилгээг хүчингүй болгох

Гэрчилгээг хүчингүй болгохгүй (гэрчилгээг хүчингүй болгохын оронд хүчингүй болсон тахограф төхөөрөмжийг “хар жагсаалт”-д оруулж зам дээрх хяналт шалгалт шалгах боломжтой болгодог).

9. МН-ГОВ болон МН-КМОБ-ын мэдээлэлийн аюулгүй байдалын удирдлага

Энэ хэсэгт бодлогод тусгагдсан мэдээлэлийн аюулгүй байдалын арга хэмжээг тодорхойлсон.

Тодруулга: Энэ хэсэгийг хамааралтай байгууллагын мэдээлэлийн аюулгүй байдалын бодлогоор бүрэн юмуу хэсэгчлэн сольж болно.

9.1 МН-ГОБ болон МН-КМОБ-ын мэдээлэлийн аюулгүй байдалын удирдлага

МН-ГОБ/МН-КМОБ хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудад нийцсэн захиргаа удирдлагын журамууд батлан мөрдөнө.

МН-ГОБ/МН-КМОБ өөрийн чиг үүрэгийг өөр байгууллагаар төлөөлүүлэн хэрэгжүүлж байсан ч түлхүүрийг гэрчилгээжүүлэх үйлчилгээний бүх үүрэг, хариуцлагыг хадгална. Гуравдагч талын үүрэг хариуцлагыг МН-ГОБ/МН-КМОБ тодорхойлж шаардсан аливаа хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэйг баталгаажуулсан арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой. МН-ГОБ/МН-КМОБ ажиллагааны журамыг бүх талд задлах үүрэгийг хадгална.

МН-ГОБ/МН-КМОБ-ын аюулгүй байдлыг удирдахад шаардлагатай мэдээлэлийн аюулгүй байдалын дэд бүтэцийг байнга нягталж, дэмжиж байна. Аюулгүй байдалд нөлөөлж болохуйц аливаа өөрчлөлтийг МН-ЭББ хянаж зөвшөөрнө.

МН-ГОБ/МН-КМОБ ISO 27002:2013 стандартад тусгасантай дүйцэхүйц аюулгүй байдалын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлсэн байна. Албан ёсоор баталгаажуулж гэрчилгээ авах шаардлагагүй.

9.2 МН-ГОБ/МН-КМОБ-ын эд хөрөнгийн ангилал болон удирдлага

МН-ГОБ/МН-КМОБ өөрийн эд хөрөнгө болон мэдээлэл зохих хамгаалалтад байгааг баталгаажуулна. Тухайлбал:

- а) МН-ГОБ/МН-КМОБ бизнесийн эрдэлүүдийг тодорхойлох, аюулгүй байдалын шаардлагууд, үйл ажиллагааны журамаа тодорхойлохын тулд эрсдэлийн үнэлгээ хийж байна.
- б) МН-ГОБ/МН-КМОБ мэдээлэлийн бүх эд хөрөнгийн тооллого, бүртгэл хийж эрсдэлийн шинжилгээний дагуу эдгээр эд хөрөнгийг хамгаалалтын шаардлагын дагуу ангилна.

9.3 МН-ГОБ/МН-КМОБ-ын хүний нөөцийн аюулгүй байдалын хяналт

9.3.1 Итгэмжлэгдсэн үүрэг роль

Энэхүү бодлогыг баримталж буй МН-ГОБ/МН-КМОБ хамгийн багадаа дор дурдсан гурван үүрэг ролийг хүлээн зөвшөөрсөн байна. Санал болгож буй загварт заасантай ижил хэмжээнд дотоодын халдлагад тэсвэртэй, тухайн үүрэг ролийг МН-ГОБ/МН-КМОБ-ын АЖ-д тусгасан нөхцөлд үүрэг ролийг хуваарилах янз бүрийн зохион байгуулалт байж болно.

Ганцаараа ажиллаж буй этгээд хамгаалалтын арга хэмжээг давах боломжгүй байхын тулд МН-ГОБ/МН-КМОБ-ын систем дахь үүрэг ролийг хэд хэдэн ажилтан, роль гүйцэтгэх ёстой. Систем дахь аккаунт бүр эзэмшигчийн үүрэг рольтой дүйцсэн хязгаарлагдмал боломжтой байх ёстой.

Санал болгож буй үүрэг роль (ажил):

- а) Гэрчилгээ олгох байгууллагын администратор юмуу мэдээлэл оруулах администратор (ГОБА/МОА)
- б) Системийн администратор (СА)
- с) Мэдээллийн системийн аюулгүй байдалын ажилтан (МАБА)

ГОБА/МОА дараах үүрэг рольтой:

- a) Түлхүүр үүсгэх;
- b) Гэрчилгээ үүсгэх; (тодорхойлсон дүрэмийн дагуу МН-ГОВ/МН-КМОВ-ын төхөөрөмж дээр явагдаж гүйцэтгэгдэх гэрчилгээнд гарын үсэг зурах хүсэлт үүсгэх)
- c) Мэдээлэл оруулах болон төхөөрөмжийг аюулгүй түгээх, хүргүүлэх;
- d) МН-ГОВ/МН-КМОВ-ын өгөгдөлийн санг хөтлөх, боловсруулах, дэмжихтэй холбоотой админы чиг үүрэг болон сэжигтэй тохиолдлыг мөрдөн шалгахад туслал.

СА дараах үүрэг рольтой:

- a) Системийн анхны тохируулгыг хийх, түүний дотор системийг аюулгүй ачаалах, асаах, унтраах тохируулга хийх;
- b) Шинэ аккаунт бүрийг үүсгэх, тохируулах;
- c) Сүлжээний анхны тохируулга хийх;
- d) Систем ослын зогсолт хийсэн, саатсан үед сэргээн ажиллуулах зориулалттай ослын дараа ачаалах, ажиллуулах тээгчийг үүсгэх;
- e) Системийн нөөц хувь бий болгох, програм хангамжийг шинэчлэх, сэргээх, түүний дотор нөөц хувь, шинэчлэлийг аюулгүй хадгалах, байгууллагаас гадагш тараах

Нөөц хувийг дараах мөчлөгтэйгөөр туршиж байна:

- a) Долоо хоногт нэг удаа шалгана, шалгасны дараа техник хангамжийн бүрэн бүтэн байдалыг шалгахын тулд системийг асааж, унтраана.
- f) Хостын нэр, сүлжээний хаяг өөрчлөгдсөн тохиолдолд.

МАБА дараах үүрэг рольтой:

- a) ГОБА/МОА -ын аюулгүй байдалын давуу эрх болон хандалтын хяналтыг тодорхойлж өгөх.
- b) Шинэ аккаунт бүрт нууц үг оноож өгөх.
- c) Системийн шаардлагатай бичлэгийг архивлах.
- d) Системийн аюулгүй байдалын бодлоготой ГОБА/МОА -ын үйл ажиллагаа нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд аудитын лог бүртгэлийг нягтлах. Нягтлах ажиллагааг долоо хоногт нэгээс доошгүй гүйцэтгэнэ.
- e) МН-ГОВ/МН-КМОВ-ын жил бүрийн бичлэгийн тооллого хийх, хянах.
- f) Монголын түлхүүр үүсгэхэд оролцох.

МАБА гэрчилгээ олгоход шууд оролцдоггүй ч системийн бүртгэл, бичлэг, аудитын лог бүртгэлийг шалгахад хяналтын чиг үүрэг гүйцэтгэх замаар бусад ажилтнууд чиг үүрэгээ аюулгүй байдалын бодлогын хүрээнд гүйцэтгэж байгааг баталгаажуулна.

9.3.2 Үүрэг ролийг тусгаарлах (салгах)

МН-ГОВ/МН-КМОВ-ын дээрх чиг үүрэгийг өөр өөр хүмүүс гүйцэтгэх ёстой ба тус бүрийг хариуцсан хүнийг томилсон байна.

9.3.3 Үүрэг роль бүрийг адилтгах, баталгаажуулах

ГОБА/МОА, СА болон МАБА-ыг адилтгах, баталгаажуулах ажиллагаа энэ бодлогод тусгасан практик, журам, нөхцөлтэй нийцсэн, түүнийг дагуу байх ёстой.

9.3.4 Суурь мэдээлэл, мэргэшил, туршлага, ажилд авахад тавигдах шаардлага

Гэрчилгээ болон түлхүүрийн мэдээлэлийг үүсгэх, удирдахад шууд оролцож буй ГОБА/МОА маш чухал албан тушаал болно. ГОБА/МОА -ын чиг үүрэгийг гүйцэтгэж буй хүн ажилдаа үнэнч, итгэлтэй, шударга байхаас гадна өдөр бүрийн ажилдаа аюулгүй байдлын шаардлагыг ухамсарлан сахиж, мэдлэгээ дээшлүүлж байна.

МН-ГОБ/МН-КМОБ-ын чухал албан тушаалд ажиллаж буй ажилтанууд, тухайлбал ГОБА/МОА болон МАБА дараах шаардлагыг хангаж ажиллана:

- a) Өөрсдийнх нь үндсэн чиг үүрэг, хариуцлагатай зөрчилдсөн бусад чиг үүрэг гүйцэтгэхгүй байх;
- b) Өмнө нь ийм төрөлийн ажлаас хариуцлагагүй байдал, үүргээ биелүүлээгүйн улмаас халагдаж байгаагүй;
- c) Чиг үүрэгээ гүйцэтгэхэд шаардлагтай зохих сургалтын дүүргэсэн.

МН-ГОБ/МН-КМОБ мэргэшил, мэдлэг, ял шийтгэлгүй байдал, зээлийн эрсдэлгүй талаас нь шалгасан ажилтан байнга ажиллаж байгааг баталгаажуулна. Эдгээр шаардлагыг хамааралтай АЖ-д тодорхойлсон байна.

9.3.5 Сургалтын шаардлага

Ажилтан өөрийн үүрэг роль, ажилд нийцсэн сургалтад хамрагдсан байна.

9.4 ГОБ болон мэдээлэл оруулах системийн аюулгүй байдалын хяналтууд

МН-ГОБ/МН-КМОБ өөрийн систем аюулгүй, зөв ажиллаж байгаа, ажиллагаанаас гарах хамгийн бага эрсдэлтэй гэдэгийг баталгаажуулна. Тухайлбал:

- a) Систем, мэдээлэлийн бүрэн бүтэн байдалыг хортой код, вирус, зөвшөөрөөгүй програм хангамж оруулахаас хамгаалагдсан байх ёстой;
- b) Будлиан зөрчилийг мэдээлэх, хариу үйлдэл хийх журам ашиглан аюулгүй байдалын будлиан зөрчил, ажиллагаа тасалдах, сатахаас учирах хохирлыг хамгийн байга болгосон байна.

ГОБ-ын систем болон КМОБ-ын систем энэ бодлого болон хамаарах АЖ-д заасаны дагуу чиг үүрэгийг тусгаарлах талаар системийн аюулгүй байдалын хяналтууд хэрэгжүүлсэн байна.

Аюулгүй байдалын хяналтууд нь МН-ГОБ-ын хувийн түлхүүрийг ашигласан аливаа ажиллагаа, үйлдэл бүрийн хандалтын хяналт, мөшгөлтийг ажилтны түвшинд хүртэл гүйцэтгэж байх ёстой.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын компьютерийн системд хэрэгжүүлсэн аюулгүй байдалын хяналтууд нь түүнд ноогдуулсан чиг үүрэгээс хамаарна. Хэрэв гэрчилгээ олгох, картад мэдээлэл оруулах, гэрчилгээг картад оруулах чиг үүрэгийг бүрэн төлөөлөн гүйцэтгэж байгаа бол МН-ГОБ/МН-КМОБ-д тавигдах шаардлагыг бүрэн хангах ёстой.

9.4.1 Компьютерийн аюулгүй байдалын техникийн шаардлагууд

МН-ГОБ-ын хувийн түлхүүр ашиглаж буй системийг ажиллуулж эхлэхэд хамгийн багадаа системд таньж баталгаажсан хойр оператор шаардагдана.

9.4.2 Компьютерийн аюулгүй байдалын зэрэглэл-үнэлгээ

ГОБ-ын болон мэдээлэл оруулах системүүд энд тусгасан шаардлагуудыг хангахын тулд албан ёсны зэрэглэл үнэлгээнд орох шаардлагагүй.

9.4.3 Системийн хөгжүүлэлтэд тавих хяналтууд

МН-ГОБ/МН-КМОБ өөрчлөлт оруулахаас хамгаалагдсан, итгэлтэй систем ашиглана.

МН-ГОБ/МН-КМОБ-ын юмуу түүний нэрийн өмнөөс төлөөлөн ажиллаж буй үйлчилгээ үзүүлэгчийн систем хөгжүүлэлтийн төслийн зохиомж, шаардлага боловсруулах шатанд аюулгүй байдалын шаардлагуудын шинжилгээ гүйцэтгэж тухай мэдээлэлийн системд аюулгүй байдлыг тусгасаныг баталгаажуулж байна.

Аливаа програм хангамжийг шинэ хувилбар гаргах, өөрчлөх, онцгой нөхцөл үүсэх үед ашиглах өөрчлөлтийн хяналтын журамтай байх ёстой.

9.4.4 Аюулгүй байдалын удирдлагын хяналтууд

9.3.1-д тусгасан Системийн үүрэг ролиудыг хэрэгжүүлж мөрддөг байна.

9.4.5 Сүлжээний аюулгүй байдалын хяналтууд

МН-ГОБ/МН-КМОБ -ын дотоод сүлжээний орчиныг гуравдагч талын хандаж болох гадаад сүлжээний орчиноос хамгаалах хяналтуудыг (ж.нь галт хана) хэрэгжүүлсэн байна.

Нууц өгөгдөлийг хамгаалагдаагүй сүлжээгээр солилцох үед хамгаалсан байх ёстой.

9.5 Аюулгүй байдалын аудитын дэг

Энэ бодлогын дагуу түлхүүр, гэрчилгээ, төхөөрөмж үлгөх үйл явцад оролцож буй бүх компьютер, системийн бүрдэлд доор тодорхойлсон аюулгүй байдалын аудит хийх дэг журам хамаарна.

9.5.1 Бүртгэх үйл явдалын төрөл

МН-ГОБ/МН-КМОБ -ын компьютер/системд хамааралтай аюулгүй байдалын аудитын чиг үүрэгийн хүрээнд дараах лог бүртгэлийг заавал хөтөлнө:

- a) Үйлдэл хийх хүсэлт, түүний хамт хүсэлт гаргаж буй аккаунт, хүсэлтийн төрөл, үйлдэл гүйцэтгэгдэж дууссан эсэх, дуусаагүй бол шалтгааны талаар бичлэгийг;
- b) Шинэ програм хангамж, шинэчлэл суулгах ажиллагаа;
- c) Бүх нөөц хуулбарын хийсэн хугацаа, огноо болон бусад тодорхойлох мэдээлэл;
- d) Системийг унтраасан, дахин эхлүүлсэн мэдээлэл;
- e) Үйлдэлийн архивын хог, үлдэгдэл үүссэн хугацаа болон огноо

9.5.2 Аудитын бүртгэлийг боловсруулах давтамж

Лог бүртгэлийг байнга боловсруулж, сэжигтэй зан үйлийн дараа шинжилнэ. Лог бүртгэлийг боловсруулах, шинжлэх журамыг АЖ-д тодорхойлно.

9.5.3 Аудитын бүртгэлийг хадгалах хугацаа

Аудитын лог бүртгэлийг хамгийн багадаа 7 жил хадгална.

9.5.4 Аудитын бүртгэлийг хамгаалах

Аудитын лог бүртгэлийг зохих ёсоор хамгаалсан байна. Оруулсан бүх бичлэг тус бүрт цагийн тэмдэглэгээ хийнэ (системийн цаг байхад хангалттай).

Аудитын лог бүртгэлийг сард нэгээс доошгүй удаа шалгаж, нэгтгэж байна. Хамгийн багадаа СА болон МАБА албан тушаалтай хоёр хүн (9.3.1) шалгах нэгтгэх үед байлцана.

9.5.5 Аудитын бүртгэлийг нөөцлөх дэг

Нэгтгэсэн лог бүртгэлийн хоёр хувийг үйлдэж биетээр тусгаарлагдсан өөр өөр байршилд хадгална.

Аудитын лог бүртгэлийг хадгалж байх хугацаанд түүнд хандах, судлах боломжтой байна. Аудитын лог бүртгэлийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалсан байна.

9.5.6 Аудитын бүртгэл цуглуулах систем (дотоод болон гадаад)

Аудитын бүртгэл цуглуулах дотоод систем шаардлагатай.

9.6 Бичлэгийг архивлах

9.6.1 МН-КМОБ-ын бүртгэж бичлэг болгох үйл явдалын төрөл

Бичлэгүүдэд МН-КОБ-ын эзэмшилд байгаа дараах хамааралтай нотлох баримтууд хамаарна: Гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

- a) МН-ГОБ/МН-КМОБ, хэрэглэгчийн хооронд солилцсон гэрчилгээний хүсэлтүүд болон хамааралтай бүх мессаж, харилцаа, хавтасууд.
- b) Хэрэглэгчийн гэрчилгээ, карт авах хүсэлтээс үүссэн, гарын үсэг зурагдсан бүртгэлийн гэрээ, түүний дотор хүсэлтийг хүлээн авч буй хүний овог нэр.
- c) Илгээсэн картыг хүлээн авсаныг баталсан гарын үсэг бүхий баримт.
- d) Гэрчилгээ болон хамаарах картын гэрээ.
- e) Гэрчилгээний сунгалт болон хэрэглэгчтэй харилцсан бүх харилцаа, мессаж.
- f) Хүчин болгох хүсэлт болон илгээсэн этгээд, хэрэглэгчтэй солилцсон бүх мессаж, харилцаа.
- g) Одоо хүчин төгөлдөр байгаа болон өмнө байсан бодлогын баримт бичигүүд.

9.6.2 МН-ГОБ/МН-КМОБ-ын бүртгэж бичлэг болгох үйл явдалын төрөл

Бичлэгүүдэд МН-КОБ-ын эзэмшилд байгаа дараах хамааралтай нотлох баримтууд хамаарна: Гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

- a) Олгосон гэрчилгээний агуулга.
- b) Аудитын бүртгэл журнал, түүний дотор МН-ГОБ/МН-КМОБ АЖ-тай нийцэж байгаа нийцэлийг шалгасан жил бүрийн аудитын тайлангууд.
- c) Одоо байгаа болон өмнө хэрэглэж байсан гэрчилгээжүүлэх бодлогынэ баримт бичиг, хамааралтай АЖ.

МН-ГОБ/МН-КМОБ юмуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтаны (ГОБА/МОА) гаргасан тоон гарын үсэгтэй цахим хүсэлтүүдийн бичлэг нь түүнийг хадгалж байх бүх хугацаанд хүсэлт бүртгэй холбоотой администраторын хувийн мэдээлэл, үл татгалзах шинжийг шалгахад шаардлагатай мэдээлэлийг агуулсан байна.

9.6.3 Архивыг хадгалах хугацаа

Архивыг АЖ-д заасан хугацаанд хадгалж өөрчлөх, устгахаас хамгаалсан байна.

9.6.4 Архивын мэдээлэлийг олж авах, шалгах дэг

МН-ГОБ/МН-КМОБ нууцлалын талаар 3.4-т заасан шаардлагыг мөрдөж ажиллана.

Тодорхой үйлдэлийн бичлэгийг тухайн үйлдэлд оролцсон аль нэг тал юмуу түүний хүлээн зөвшөөрөгдсөн төлөөлөгчийн хүсэлтээр гаргаж өгч болно.

МН-ГОВ/МН-КМОВ 11.5-ын дагуу хамаарах АЖ-д МН-ГОВ/МН-КМОВ нийцэж байгаа тухай баримт бичигийг хүсэлтийн дагуу гаргаж өгөх ёстой.

Бичлэгийг гаргаж өгөх зардалыг нөхөх зохистой хэмжээний төлбөрийг хуулийн дагуу тогтоож болно.

МН-ГОВ/МН-КМОВ архивын хүртээмжтэй байдалыг хангах бөгөөд үйл ажиллагаагаа зогсоосон, татан буугдсан байсан ч архивласан мэдээллийг тогтоосон хугацаанд уншигдахуйц форматаар хадгална.

Хэрэв МН-ГОВ/МН-КМОВ -ын үйл ажиллагаа тасалдсан, зогссон, татан буугдсан бол архивын байнгын хүртээмжтэй байдалыг хангах үүднээс бүх байгууллага-үйлчлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. Архивын мэдээлэлд хандах бүх хүсэлтийг МН-ГОВ/МН-КМОВ юмуу түүний чиг үүрэгийг гүйцэтгэж буй этгээдэд илгээнэ.

9.7 МН-ГОВ/МН-КМОВ -ын тасралтгүй ажиллагааны төлөвлөлт

МН-ГОВ/МН-КМОВ бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй (ТАТ) байна. Энэ төлөвлөгөөнд дараах учрал, үйл явдалыг (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) заавал оруулна:

- Түлхүүр эрсдэлд орох, эвдлүүлэх.
- Хулгай, гал, техник хангамж, програм хангамж эвдэрсэний улмаас өгөгдөл ноцтой эрсдэлд орох, алдагдах
- Бусад байдлаар систем ажиллагаагүй болох.

9.7.1 Монголын түлхүүрүүд эрсдэлд орох

Монголын түлхүүрүүд эрсдэлд орвол 6-р хэсэгт заасаны дагуу зохицуулна.

9.7.2 Бусад гамшигийн дараа сэргээн ажиллуулах

МН-ГОВ/МН-КМОВ болон гэрээт байгууллагууд системийн осол аваарыг сэргийлэх, бага хэмжээнд байлгах журамтай байна. Энэ журамд ТАТ-д тодорхойлогдсон байх ёстой нөөц өгөгдөлийг аюулгүй болон зайнаас хадгалах, өгөгдөлийг сэргээх дэгийг тусгасан байна.

9.8 ГОВ болон мэдээлэл оруулах системийн биет аюулгүй байдалын хяналт

МН-ГОВ/МН-КМОВ -ын техник хангамж, програм хангамжид биетээр хандах хандалтыг хянах биет аюулгүй байдалын хяналтууд хэрэгжүүлсэн байна. Энэ хяналтад ГОВ-ын болон мэдээлэл оруулах ажлын компьютерууд, бусад техник, аливаа гаднах криптографын тоног төхөөрөмж, карт хамрагдсан байна. Эдгээр талбарт хандаж буй бүх биет хандалтыг бүртгэж байна.

Гэрчилгээнд гарын үсэг зурах Монголын түлхүүрүүд АЖ-д заасаны дагуу биет болон логик хамгаалалттайгаар хадгалагдана.

МН-ГОВ/МН-КМОВ -ын байранд нөөц хуулбар болон тээгчийг алдах, солих, зөвшөөрөлгүй ашиглахаас сэргийлсэн байдлаар хадгалах өрөө байх ёстой. Нөөц хуулбарыг өгөдөл сэргээх болон чухал мэдээлэлийг архивлахын тулд хадгална. Гамшигийн үед үндсэн байр, системийг сэргээн ажиллуулахын тулд Нөөц хуулбарын тээгчийг МН-ГОВ/МН-КМОВ -ын систем байгаа газараас өөр газарт хадгална.

МН-ГОВ/МН-КМОВ-ын үндсэн төхөөрөмжүүд байрласан байр, объектын аюулгүй байдалын шалгалтыг 24 цагт нэгээс доошгүй удаа гүйцэтгэнэ. Хэрэв байр объектыг байнга хянадаг бол систем, хамааралтай криптографын төхөөрөмж, картууд найдвартай хадгалагдаж байгаа, биет аюулгүй байдалын систем (цоож, дохиолол г.м) хэвийн байгаа, эвдлэх, хууль бусаар хандах оролдлого хийгдээгүй гэдэгийг баталгаажуулахын тулд энэ шалгалтыг ээлжиндээ нэг удаа

нүдээр харж шалгаж болно.

9.8.1 Биеэр хандах хандалт

Монголын түлхүүрүүд болон тэдгээрийг ашиглах хэрэгсэлийг байршуулсан, хадгалж буй байршилд биетээр хандахад тухайн орчинд хандах эрх бүхий хоёроос доошгүй хүн байлцана.

МН-ГОБ/МН-КМОБ -ын бусад байр, орчинд биетээр хандах хүн нь 9.3.1-д заасан үүрэг ролийг гүйцэтгэж буй хэн нэгэн байж болно. Систем байршуулсан өрөөнд хандах хандалтыг орсон хүмүүсийн зөвшөөрөл болон бүртгэлийн дэвтэр, жагсаалт хөтлөх замаар хянаж болно. Хандалтыг зөвшөөрсөн жагсаалтанд ороогүй хүнийг жагсаалтад орсон хэн нэгэн заавал дагалдах ёстой. Зарим газарт хандалтыг зөвшөөрсөн жагсаалт байхгүй бол ГОБ-ын гэрчилгээ олгох, мэдээлэл оруулахтай холбоотой материал аюулгүй өрөө, хадгаламжид хадгалагдсан байх ёстой.

10. МН-ГОБ юмуу МН-КСОБ-ын ажиллагааг дуусгавар болгох

10.1 Ажиллагаагаа бүрэн дуусгавар болгох – МН-ЭББ-ын чиг үүрэг

МН-ГОБ юмуу МН-КМОБ-ын үйл ажиллагааг бүрэн дуусгавар болгоно гэдэгт тухайн логик этгээдтэй холбоотой бүх үйлчилгээ бүрэн зогссон нөхцөл байдалыг ойлгоно. Энэ нь үйлчилгээг нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлж байгаа, эсхүл МН-ГОБ-ын үйлчилгээг хуучин хос түлхүүрээс шинэ хос түлхүүрт, эсхүл ЕСГБ-ын түлхүүрт шилжүүлж байгаа асуудал биш.

МН-ЭББ дараах чиг үүрэгийг хангаж гүйцэтгэнэ: Тодруулга: МН-ГОБ/МН-КМОБ үйл ажиллагаагаа бүрэн дуусгавар болгоно гэдэг нь Монгол Улс тахографын системээс гарах, эсхүл ГОБ байхгүйн улмаас тахографын системийн ажиллагааг зогсоохыг ойлгоно.

МН-ГОБ/МН-КМОБ үйл ажиллагаагаа бүрэн дуусгавар болгохын өмнө дараах ажиллагааг заавал гүйцэтгэнэ:

- a) МН-ГОБ/МН-КМОБ -тай гэрээ байгуулсан, бусад хэлбэрээр харилцаатай хэрэглэгч, талуудад мэдээлэл хүргэх.
- b) Үйл ажиллагаагаа дуусгавар болгохоос 3-аас доошгүй сарын өмнө энэ тухай мэдээлэлийг нийтэд мэдээлэх.
- c) Гэрчилгээ олгох үйл явцад МН-ГОБ/МН-КМОБ -ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй бүх үйлчилгээ үзүүлэгч, туслан гүйцэтгэгчийн эрхийг хааж, хамааралтай ажиллагааг зогсоох.
- d) Архивын бичлэгийг хадгалах хугацаанд нь хөтлөх үүрэгийг шилжүүлэх өгөх арга хэмжээ авах.

10.2 МН-ГОБ юмуу МН-КМОБ-ын үүрэг хариуцлагыг шилжүүлэх

МН-ЭББ өмнөх МН-ГОБ юмуу МН-КМОБ-ын оронд шинэ байгууллага томилохоор шийдвэр гаргасан бол МН-ГОБ юмуу МН-КМОБ-ын үүрэг хариуцлагыг шилжүүлнэ.

Үүрэг хариуцлаг болон эд хөрөнгийг зохион байгуулалттай шилжүүлэх ажиллагааг МН-ЭББ хангана.

Хуучин МН-ГОБ бүх суурь түлхүүрийг МН-ЭББ-ын сонгосон аргаар шинэ МН-ГОБ-д шилжүүлнэ. Шилжүүлээгүй түлхүүрийн бүх хувийг хуучин МН-ГОБ устгана.

11. Аудит

МН-ГОБ болон МН-КМОБ-д аудит хийгдэж байгааг баталгаажуулах үүрэгийг МН-ЭББ хариуцана.

11.1 Нийцэлийн аудитын давтамж

Энэ бодлогын дагуу ажиллаж буй МН-ГОБ/МН-КМОБ жилд нэгээс доошгүй удаа энэ бодлоготой нийцэх нийцэлийн аудитад орно.

11.2 Аудитаар шалгах сэдэвүүд

Аудитаар МН-ГОБ/МН-КМОБ-ын практик ажиллагааг тэдний АЖ-ын дагуу нягтална. Мөн энэ бодлоготой нийцэх нийцэлийг нягтална. Аудитаар ЕСГБ-ын АЖ-ын §5.3 -д тодорхойлсон шаардлагуудыг нягтална. Түүнчлэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын үйл ажиллагааг нягтлан үзнэ.

11.3 Аудит гүйцэтгэх этгээд

Хэрэгжүүлэлтийн явцад хамааралтай талуудын итгэлийг дээшлүүлэх зорилгоор МН-ГОБ/МН-КМОБ-ын АЖ-ыг батлуулахын тулд МН-ЭББ гадны гэрчилгээжүүлэх юмуу баталгаажуулах байгууллагатай зөвлөлдөж болно. Бусад тохиолдолд МН-ЭББ аудитыг гүйцэтгэнэ.

11.4 Алдаа гажуудлын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ

Аудитын явцад зөрчил, алдаа, гажуудал илэрвэл МН-ЭББ ноцтой байдлын түвшингээс хамаарсан зохих арга хэмжээ хэрэгжүүлнэ.

11.5 Үр дүнг танилцуулах

Аюулгүй байдалын төлөвийн түвшингийн талаар аудитын үр дүнг хүсэлтийн дагуу гаргаж өгнө. Аудитын нийт үр дүнг зөвхөн албан ажлын шаардлагаар гаргаж өгнө.

МН-ЭББ аудитын үр дүнг тайлан болгон гаргах бөгөөд тайланд МН-ЭББ-ын үүрэгийг биелүүлэхэд шаардлагатай засах залруулах ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх хуваарийг тусгана. Тайланг англи хэл дээр ЕСГБ-д илгээнэ.

12. Энэ бодлогод өөрчлөлт оруулах журам

12.1 Мэдэгдэл хүргүүлэлгүй өөрчилж болох зүйлс

Мэдээлэл хүргүүлэлгүй дараах зүйлсийг өөрчилж болно:

- a) Хянан тохиолдуулах, хэвлэлийн алдаа засах.
- b) Харилцах хаяг, мэдээлэлд оруулах өөрчлөлт

12.2 Мэдэгдэлийн үндсэн дээр оруулах өөрчлөлт

12.2.1 Мэдэгдэл

Энэ бодлогод оруулж буй аливаа өөрчлөлтийн талаар 90-ээс доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

МН-ЭББ-ын үзсэнээр ихэнх хэрэглэгч болон хамааралтай талд бодитой нөлөөлж чадахгүй жижиг өөрчлөлтүүдийн талаар 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

12.2.2 Санал ирүүлэх хугацаа

Өөрчлөлтийн нөлөөлөлд орж буй хэрэглэгч мэдэгдэлийг хүлээн авсанаас хойш 15 хоногийн дотор бодлогын хариуцаж буй байгууллагад өөрийн саналыг ирүүлнэ.

12.2.3 Хэнд мэдээлэх вэ

Энэ бодлогод оруулж буй өөрчлөлтийн талаар мэдээлэлийг дараах газарт илгээнэ:

- ЕСГБ-ERCA.
- МН-ГОБ болон МН-КМОБ, түүний дотор үйлчилгээ үзүүлэгч байгуулага.

- Хэлэцээрт нэгдсэн бусад бүх улсын эрх бүхий байгууллага.
- Хамааралтай ТХ үйлдвэрлэгч болон хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгч

12.2.4 Өөрчлөлтийн талаар эцсийн мэдэгдэл гаргах хугацаа

Санал болгож буй өөрчлөлтийг ирсэн саналуудын дагуу өөрчлөх болсон бол энэ тухай мэдэгдэлийг өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө илгээнэ.

12.3 ГОББ-ыг (энэ бодлого) шинэчлэн батлах шаардлага үүсгэдэг өөрчлөлт

МН-ЭББ-аас бодлогыг хэрэглэгч буй ихэнх хэрэглэгчид бодлогын өөрчлөлт ноцтой нөлөөлөл үзүүлнэ гэж үзэж байгаа бол өөрчлөлт оруулж нягтлан хянасан бодлогыг ЕСГБ-д илгээж батлуулна.

13. Ном зүй

[BPM] Digital Tachograph Card Issuing Best Practice Manual. Card Issuing Group, 16 November 2001. - owned by the European Commission.

[CC] Common Criteria. ISO/IEC 15408 (1999): "Information technology - Security techniques - Evaluation criteria for IT security (parts 1 to 3)".

[CEN] CEN/TS 419261 (Security Requirements for Trustworthy Systems Managing Certificates and Time- Stamps))

[ETSI 102 042] ETSI TS 102 042. Policy requirements for certification authorities issuing public key certificates

[FIPS] FIPS PUB 140-2 (May 25, 2001): "Security Requirements for Cryptographic Modules". Information Technology Laboratory, National Institute of Standards and Technology (NIST)

[ISO 27002] ISO/IEC 27002:2013. Information technology -- Security techniques – Code of practice for information security controls.

[CSG] Common Security Guideline, Card Issuing Project. – owed by the European Commission

[EU165] Regulation (EU) 165/2014 on Tachographs in Road Transport, repealing Council Regulation (EEC) NO 3821/85 on Recording Equipment in Road Transport and amending Regulation (EC) NO 561/2006

[EU799] Commission Implementing Regulation (EU) 2016/799 of 18 March 2016 implementing Regulation (EU) No 165/2014 of the European Parliament and of the Council

[EU502] Commission Implementing Regulation (EU) 2018/502 of 28 February 2018 amending Implementing Regulation (EU) 2016/799

[SEC] European Digital Tachograph Common Security Guidelines Version 1.0 of 05.11.2002

[ERCA] Digital Tachograph System European Root Policy, Version 2.1; published at <https://dtc.jrc.ec.europa.eu/>.

[EU679] EU General Data Protection Regulation 2016/679 – GDPR adopted on 14 April 2016

14. Нэр томъёоны тайлбар/Тодорхойлолт болон товчлол

14.1 Нэр томъёо/Тодорхойлолт

CA Policy - ГОБ-ын бодлого: Түлхүүр, гэрчилгээ болон төхөөрөмжийг аюулгүй байдлын нийтлэг шаардлага тавигддаг тодорхой бүлэг болон хэрэглээний програмд ашиглах багц дүрэм.

Card/Tachograph cards – Карт/Тохагорафын картууд: Интеграл схем бүхий карт бөгөөд (ИН-карт) болон “Ухаалагч карт” гэдэгтэй ижил утгатай.

Card holder – Карт эзэмшигч: Тахографын картыг эзэмшигч болон хэрэглэгч хувь хүн, байгууллага. Үүнд жолооч, компанийн төлөөлөгч, засвар үйлчилгээний газарын ажилтан болон хяналтын байгууллагын ажилтан хамаарна.

Certificate - Гэрчилгээ: Нийтлэг утгаар нь авч үзвэл гэрчилгээнд байгаа мэдээлэл үнэн зөв, гэрчилгээжсэн нийтийн түлхүүрийг эзэмшигч нь хамаарах хувийн түлхүүрийг эзэмшиж байгаа гэдэгийг нотолсон олгогчийн гарын үсэгийг агуулсан мэдээлэлийн бүтэц.

Certification Authority System (CAS) – Гэрчилгээ олгогч байгууллагын систем (ГОБС): ГОБ-ын хувийн түлхүүрийн тусламжтайгаар тухайн (хэрэглэгчийн) гэрчилгээний өгөгдөлд гарын үсэг зурж баталгаажуулах замаар гэрчилгээ олгож буй систем.

Certification Practice Statement (CPS) – Гэрчилгээжүүлэх ажиллагааны журам (ГАЖ): Гэрчилгээ олгох байгууллага гэрчилгээ олгох үедээ ашигладаг, энэ бодлоготой холбогдсон, үйл ажиллагаа, практикийн талаарх журам - мэдэгдэл. Энэ бодлого дахь ГАЖ-ыг Ажиллагааны Журам (АЖ) -аар сольсон, яагаад гэвэл түлхүүр, гэрчилгээ болон төхөөрөмжтэй холбоотой өргөн хүрээг хамардаг.

Equipment - Төхөөрөмж: Тахографын системд дараах төхөөрөмж байдаг: Тахографын картууд, Тээвэрийн хэрэгсэл (ТХ) болон Хөдөлгөөн мэдрэгч.

Manufacturer/Equipment manufacturer - Үйлдвэрлэгч/Төхөөрөмж үйлдвэрлэгч: Тахографын төхөөрөмжийг үйлдвэрлэгч. Энэ бодлогод ихэнхдээ ТХ болон хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгчийг авч үзсэн, яагаад гэвэл тэд системд өөр өөр үүрэг рольтой.

Motion Sensor key - Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд: Хөдөлгөөн мэдрэгч болон ТХ бие биеэ харилцан таньж зөвшөөрөхийн тулд тэнд ашиглаж буй тэгш хэмт түлхүүрүүд.

Practice Statement (PS) – Ажиллагааны журам (АЖ). Тахографын үйл явцад хэрэглэж буй аюулгүй байдалыг хангах ажиллагааны журам – мэдэгдэл. АЖ нь Нийтийн Түлхүүрийн Дэд Бүтэцийн (НТДБ) ГАЖ-ын стандарт баримт бичигтэй нийцсэн байна.

Private key - Хувийн түлхүүр: Нийтийн түлхүүрээр шифрлэдэг аргад ашиглагддаг тэгш бус хос түлхүүрийн хувийн түлхүүр-хэсэг. Хувийн түлхүүрийг ихэвчлэн тоон гарын үсэг зурах, таньж баталгаажуулах болон мэдээлэлийн шифрлэлтийг тайлахад ашигладаг. Түүнчлэн “нууц түлхүүр” гэж нэрлэгддэг.

Public key – Нийтийн түлхүүр: Нийтийн түлхүүрээр шифрлэдэг аргад ашиглагддаг тэгш бус хос түлхүүрийн нийтийн түлхүүр-хэсэг. Нийтийн түлхүүрийг ихэвчлэн тоон гарын үсэгийг шалган баталгаажуулах, хувийн түлхүүр эзэмшигчид илгээж буй мэдээлэлийг шифрлэхэд ашигладаг.

RSA keys – RSA түлхүүрүүд: RSA нь Тахографын систем дахь тэгш бус (НТДБ) түлхүүрүүдэд ашиглаж буй криптографын алгоритм. Rivest, Shamir and Adleman -ын товчлол

Service Agency/Provider - Үйлчилгээ үзүүлэгч байгууллага: МН-ГОБ юмуу МН-КМОБ-ын нэрийн өмнөөс тэдний чиг үүрэгийг гүйцэтгэж буй туслан гүйцэтгэгч.

Tachograph cards/Cards - Тахографын картууд/карт: Тахографын системд ашиглах дөрвөн төрөлийн ухаалагч карт: Жолоочийн карт, Компанийн карт, Засвар үйлчилгээний газарын карт, Хяналтын карт.

User - Хэрэглэгч: Төхөөрөмжийн хэрэглэгчид бөгөөд карт эзэмшигчид, эсхүл ТХ-ийн үйлдвэрлэгч, хөдөлгөөн мэдрэгч үйлдвэрлэгч байна. Бүх хэрэглэгч нь хосгүй адилтгагдах этгээд байна.

Энэ баримт бичигт:

Signed – Гарын үсэг зурсан: Энэ бодлогоор гарын үсэг шаардсан бол аюулгүй, шалгагдахуйц тоон гарын үсэг шаардлагыг хангана.

Written - Бичгийн хэлбэртэй: Энэ бодлогоор мэдээлэлийг бичгийн хэлбэртэй байхыг шаардсан бол доторхи мэдээлэлд сонирхсон талууд хандах боломжтой өгөгдөлийн мессаж шаардлагыг хангана.

14.2 Төвчлөл

CA Certification Authority – **ГОб** - Гэрчилгээ олгох байгууллага

CAA/PA Certification Authority Administrator/ Personalization Administrator – **ГОбА/МОА**
Гэрчилгээ олгох байгууллагын администратор/мэдээлэл оруулах администратор

CAS Certification Authority System – **ГОбС** Гэрчилгээ олгох байгууллагын систем

CIA Card Issuing Authority – **КОб** Карт олгох байгууллага

CC Common Criteria – **НШ** Нийтлэг шалгуур

CP Card Personalizing organization – **КМОБ** Картад мэдээлэл оруулах байгууллага (Картанд эзэмшигчийн мэдээлэл оруулах, карт дээрх зураг, мэдээлэлийг хэвлэн буулгах чиг үүрэгтэй)

CPS Certification Practice Statement – **Гаж** Гэрчилгээжүүлэх ажиллагааны журам - мэдэгдэл

ERCA European Root CA – **ЕСГБ** Европын суурь гэрчилгээжүүлэх (гэрчилгээ олгох) байгууллага

ISSO Information System Security Officer – **МабА** Системийн мэдээлэлийн аюулгүй байдалын ажилтан

ITSEC Information Technology Security Evaluation Criteria – **МТАБШ** Мэдээлэлийн технологийн аюулгүй байдалын үнэлгээний шалгуур

KG Key Generation – **Тү** Түлхүүр үүсгэх

MS Member State – **ГУ** Гишүүн улс (ЕХ-ны гишүүн улсууд болон хэлэлцээрт нэгдсэн улс)

MNA Mongolian Authority – **МН-ЭББ** Монголын эрх бүхий байгууллага (ЗТХЯ)

MNCA Mongolian CA – **МН-ГОб** Монголын гэрчилгээ олгох байгууллага

PKI Public Key Infrastructure – **НТДБ** Нийтийн түлхүүрийн дэд бүтэц

SA System Administrator – **Са** Системийн администратор

PS Practice Statement – **Аж** Ажиллагааны журам

VU Vehicle Unit – **Тх** Тээвэрийн хэрэгсэл

VUP VU Personalizing organization – **ТхМОБ** Тээвэрийн хэрэгсэлд мэдээлэл оруулах байгууллага

CSR – Certificate Signing Request-Гэрчилгээнд гарын үсэг зурах хүсэлт

KDM – Key Distribution Message- Түлхүүр түгээх (хуваарилах) тухай мессаж

KDR – Key Distribution Request – Түлхүүр түгээх (хуваарилах) хүсэлт

CSP – Certificate Service Provider – Гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлэгч (ГҮҮ)

KCR – Key Certificate Request – Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт

SK – Secret Key – Хувийн нууц түлхүүр (ХТ)

PK – Public key – Нийтийн түлхүүр (НТ)

C – Certificate – Гэрчилгээ, **N.C** – Үндэсний гэрчилгээ

N.C – National certificate – Үндэсний гэрчилгээ

MC – Mongolian Certificate – Монголын гэрчилгээ

MSA – Member State Authority – **ГҮ-ЭББ** Гишүүн улсын эрх бүхийн байгууллага

ERCA – European Root Certification Authority – Европын суурь гэрчилгээ олгох (гэрчилгээжүүлэх) байгууллага

Eqт – Equipment - Төхөөрөмж

15. ЕСГБ-ын бодлоготой нийцэх нийцэлийн хүснэгт

Монголын ГОБ-ын бодлогод тавигдах шаардлагуудыг ЕСГБ-ын бодлогын § 5.3-ын дагуу гаргасан. Дараах хүснэгтэд ЕСГБ-ын бодлогод томъёологдсон шаардлагууд болон Монголын ГОБ-ын бодлогын шаардлагуудын хамаарал, нийцэлийг харуулсан.

Д/д	ЕСГБ-ын заалт	Шаардлага	Монголын ГОБ-ын бодлогын заалт
1	§ 5.3.1	ГУ-ЭББ-ын бодлогыг хариуцсан байгууллагыг тодорхойлсон байна	§1.1 Хариуцсан байгууллага
2	§ 5.3.2	<p>ГУ-ГОБ-ын төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх болон хөдөлгөөн мэдрэгчийг түлхүүрийг түгээх хос түлхүүр дараах шаардлага хангасан төхөөрөмж дээр үүсгэгдэж хадгалагдана:</p> <ul style="list-style-type: none"> • FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагыг хангасан; эсхүл • CEN/TS 419261 (Гэрчилгээ болон цагийн тэмдэглэгээгээр удирдагдаж буй итгэлтэй системд тавигдах аюулгүй байдалын шаардлага) [CEN] хангасан, • Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем, • Дүйцэхүйц аюулгүй байдалын түвшинг хангаж буйгаа харуулсан систем 	<p>§6.2.1 Монголын түлхүүрүүдийг үүсгэх</p> <p>§6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт</p> <p>§6.4 Дамжуулалтын түлхүүрүүд</p> <p>§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт</p>
3	§ 5.3.3	Гишүүн улсын хос түлхүүр үүсгэх ажиллагааг аюулгүй орчинд итгэмжлэгдсэн үүрэг рольтой хүмүүс давхар хяналтад гүйцэтгэнэ.	<p>§6 Суурь түлхүүрүүд болон дамжуулалтын түлхүүрүүдийн удирдлага: Европын суурь түлхүүр, Монголын түлхүүрүүд, Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд, дамжуулалтын түлхүүрүүд [бүлэг 8]</p> <p>§6.2.1 Монголын түлхүүрүүд үүсгэх</p>
4	§ 5.3.4	ГУ-ын хос түлхүүрийг ЕСГБ-аас гэрчилгээжүүлсэнээс хойш 2 жилийн хугацаанд ашиглана.	§6.2.2 Монголын түлхүүрүүдийн хүчинтэй хугацаа
5	§ 5.3.5	ГУ-ын шинэ хос түлхүүр үүсгэхдээ ЕСГБ-аас гэрчилгээжүүлэхэд шаардагдах нэг сарын хугацааг анхааралдаа авна.	§6.2.1 Монголын түлхүүрүүд үүсгэх

6	§ 5.3.6	ГУ-ЭББ хавсралт А-д тодорхойлсон түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлтийн протокол ашиглан ГУГОБ-ын нийтийн түлхүүрийг ЕСГБ-д гэрчилгээжүүлэхээр илгээнэ.	§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт
7	§ 5.3.7	ГУ-ЭББ хавсралт А-д тодорхойлсон түлхүүр түгээх хүсэлтийн протокол ашиглан хөдөлгөөн мэдрэгчийн мастер түлхүүрийг ЕСГБ-аас хүсэнэ.	§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт
8	§ 5.3.8	ГУЭББ ЕСГБ-ын нийтийн түлхүүрийг хавсралт В-д тусгасан түгээх маягтын дагуу хүлээн зөвшөөрнө.	§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт
9	§ 5.3.9	ГУЭББ хавсралт С-д заасаны дагуу түлхүүр болон гэрчилгээ дамжуулах биет тээгч ашиглана.	§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт
10	§ 5.3.10	ЕСГБ-д илгээсэн түлхүүрийн адилтгагч (KID) болон түлхүүрийн (n) модуль ГУГОБ-ын домэйн хосгүй гэдэгийг ГУЭББ баталгаажуулна.	§6.5 Түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт
11	§ 5.3.11	Хугацаа дууссан түлхүүрүүдийг аливаа зорилгоор ашиглахгүй гэдэгийг ГУЭББ баталгаажуулна. ГУ-ын хувийн түлхүүрийг: Дахин сэргээх боломжгүйгээр устгах; эсхүл ашиглах боломжгүйгээр хадгална.	§6.2.7 Монголын түлхүүрүүд дуусгавар болох
12	§ 5.3.12	Төхөөрөмжийн RSA түлхүүрийг нууцлал, бүрэн бүтэн байдалыг хангасан байдалаар үүсгэж, дамжуулж, төхөөрөмжид оруулсан гэдэгийг ГУЭББ баталгаажуулна. Үүний тулд ГУЭББ: а) Төхөөрөмжийн гэрчилгээн дээрх аюулгүй байдалын зааварыг биелүүлэх. б) Үүсгэх, оруулах ажиллагааг аюулгүй байдалыг хангасан орчинд гүйцэтгэж буй баталгаажуулах; в) Түлхүүр үүсгэх ажиллагаа төхөөрөмжийн аюулгүй байдалын гэрчилгээнд хамаараагүй бол зориулалтын, зохистой криптограф түлхүүр үүсгэдэг алгоритм ашиглаж байгааг баталгаажуулах; Үүсгэхэд тавигдах сүүлийн хоёр шаардлага нь дараах шаардлагыг хангасан төхөөрөмж дээр түлхүүр үүсгэх шаардлагатай нийцсэн байх ёстой: с. FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагын дагуу баталгаажсан; d. CEN/TS 419261 [CEN] -д тодорхойлсон шаардлагын дагуу баталгаажсан.	§5.1.1 Чанарын хяналт – ИН-ГОБ/МН-КМОБ-ын чиг үүрэг §7.1 ГОБ/МН-КМОБ үйлчилгээ үзүүлэгч, ТХ үйлдвэрлэгчийн нийтлэг асуудал §7.2 Төхөөрөмжийн түлхүүр үүсгэх

		<ul style="list-style-type: none"> Олон талын эрсдэлийн шинжилгээ, аюулгүй байдалын бүтэцийн болон техникийн бус арга хэмжээний дагуу энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажигж гэрчилгээ авсан итгэлтэй систем, d) Дүйцэхүйц аюулгүй байдалын түвшинг хангаж буйгаа харуулсан систем 	
13	§ 5.3.13	ГУ-ын ГОББ-ын дагуу үүсгэж, хадгалж, ашиглаж буй хувийн түлхүүрийн нууцлал, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдалыг ГУЭББ хангана.	§3.4.1 Нууцлах ёстой мэдээлэлийн төрөл §6.2.1 Монголын түлхүүр үүсгэх §6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт §6.4 Дамжуулалтын түлхүүрүүд §7.2 Төхөөрөмжийн түлхүүр үүсгэх
14	§ 5.3.14	ГУЭББ ГОББ-ын дагуу үүсгэж, хадгалж, ашиглаж буй хувийн түлхүүрийг хууль бус ашиглахаас сэргийлнэ.	§6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт §6.4 Дамжуулалтын түлхүүрүүд §7.2 Төхөөрөмжийн түлхүүр үүсгэх §7.2.3 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хамгаалах, хадгалах – карт
15	§ 5.3.15	ГУ-ын хувийн түлхүүрийг түлхүүр сэргээх журамтай дагуу давхар хяналтын дор нөөцөлж болно.	§6.2.1 Монголын түлхүүр үүсгэх §6.2.4 Монголын хувийн түлхүүрийн нөөц хуулбар
16	§ 5.3.16	Хувийн түлхүүрийг дамжуулж буй түлхүүр гэрчилгээжүүлэх хүсэлтийг зөвшөөрөхгүй.	§6.5 Түлхүүр гэрчилгээжүүлэх хүсэлт болон хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг түгээх хүсэлт 7.2.3 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хамгаалах, хадгалах – карт
17	§ 5.3.17	Түлхүүр хадгалуулахыг хатуу хориглоно	§6.2.5 Монголын хувийн түлхүүрийг хадгалуулах §7.2.5 Төхөөрөмжийн хувийн түлхүүрийг хадгалуулах, архивлах
18	§ 5.3.18	ГУЭББ хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг хууль бусаар ашиглахаас сэргийлнэ.	§6.3 Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд
19	§ 5.3.19	ГУЭББ хөдөлгөөн мэдрэгчийн мастер түлхүүрийг (Km) зөвхөн хөдөлгөөн мэдрэгчийг үйлдвэрлэх үед түүний өгөгдөлийг шифрлэхэд ашиглаж буйг баталгаажуулна. Шифрлэгдэх өгөгдөлийг ISO / IEC 16844-3 стандартад тодорхойлсон.	Хэрэглэгдэхгүй
20	§ 5.3.20	Хөдөлгөөн мэдрэгчийн мастер түлхүүрийг (Km) ГУЭББ-ын аюулгүй, хяналттай орчиноос гаргаж болохгүй.	Хэрэглэгдэхгүй

21	§ 5.3.21	ГУЭББ засвар үйлчилгээний газарын картын хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг (KmWC) бүрдэл хэсэгт мэдээлэл оруулагчид (энэ тохиолдолд картад өгөгдөл оруулах үйлчилгээ) аюулгүй хэрэгсэлээр, зөвхөн засвар үйлчилгээний газарын картад оруулах зорилгоор илгээнэ.	§6.3 Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд
22	§ 5.3.22	ГУЭББ тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийг (KmVU) бүрдэл хэсэгт мэдээлэл оруулагчид (энэ тохиолдолд картад өгөгдөл оруулах үйлчилгээ) аюулгүй хэрэгсэлээр, зөвхөн тээврийн хэрэгсэлт оруулах зорилгоор илгээнэ.	Хэрэглэгдэхгүй
23	§ 5.3.23	ГУЭББ хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийн хувийн нууцлал, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдлыг хангана.	§6.3 Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд
24	§ 5.3.24	ГУЭББ дараах шаардлагыг хангасан төхөөрөмж дотор хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрийн хувийг хадгалж буйг баталгаажуулна: а) FIPS 140-2 (эсхүл 140-1) level 3 [FIPS] юмуу түүнээс дээш шаардлагын дагуу баталгаажсан; б) энэ бодлогын шаардлагыг хангаж буй Аюулгүй байдалын профайл юмуу аюулгүй байдалын зааварчилгаанд (“Аюулгүй байдалын зорилтууд”) суурилан ISO 15408 [CC] стандартын дагуу EAL 4 юмуу түүнээс дээш, эсхүл E-3 [ITSEC] түвшин хүртэл баталгаажиж гэрчилгээ авсан итгэлтэй систем.	§6.3 Хөдөлгөөн мэдрэгчийн түлхүүрүүд
25	§ 5.3.25	ГУЭББ ТХ болон тахографын картын төхөөрөмжийн нийтийн түлхүүрийн гэрчилгээ үүсгэхийн тулд ГУ-ын ялгаатай хос түлхүүрүүдийг эзэмшиж байна.	Хэрэглэгдэхгүй
26	§ 5.3.26	ГУЭББ төхөөрөмжийн нийтийн түлхүүр гэрчилгээжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй болгосон байна.	§6.2.1 Монголын түлхүүрүүд үүсгэх
27	§ 5.3.27	ГУЭББ өөрийн улсын хувийн түлхүүрийг дараах зорилгоор ашиглана: а) Хавсралт I(B)-ийн хавсралт 11 “Аюулгүй байдалын нийтлэг механизм”-д тодорхойлсон тоон гарын үсэгийн алгоритм, ISO / IEC 9796-2 стандарт ашиглан Хавсралт I(B)-ийн төхөөрөмжийн түлхүүрийн гэрчилгээг үүсгэх; б) ЕСГБ-ын түлхүүр гэрчилгээжүүлэх хүсэлтийг Хавсралт А-д заасанаар үүсгэх. с) Хэрэв тухайн аргыг гэрчилгээний төлөвийн мэдээлэл гаргахад ашиглаж байгаа бол хүчингүй гэрчилгээний жагсаалт гаргахад (5.3.30).	§6.2 Монголын түлхүүрүүд

28	§ 5.3.28	ГУЭББ хувийн түлхүүрүүд хадгалсантай ижил төхөөрөмж дээр төхөөрөмжийн гэрчилгээнд гарын үсэг зурна.	§6.2.3 Монголын хувийн түлхүүрийн хадгалалт
29	§ 5.3.29	ГУЭББ өөрийн домэйний хүрээнд төхөөрөмжийн нийтийн түлхүүрийг Хасвралт 1(В) -д заасны дагуу хосгүй түлхүүр адилтгагчаар адилтгагдсан байхыг баталгаажуулна.	§7.2 Төхөөрөмжийн түлхүүр үүсгэх §8.1.1 Тахографын картууд
30	§ 5.3.30	Түлхүүр үүсгэх, гэрчилгээжүүлэх ажиллагааг аюулгүй орчинд гүйцэтгэсэнээс үл хамааран түлхүүрийг гэрчилгээжүүлэх хүсэлтийн протокол нь хувийн түлхүүрийг харуулахгүйгээр гарал үүсэл, хүсэлтийн бүрэн бүтэн байдалын нотолгоог хангана.	§8.1.1 Тахографын картууд
31	§ 5.3.31	ГУЭББ гэрчилгээний төлөвийн мэдээлэлийг хөтөлж хүртээмжтэй байлгана.	§8.7 Төхөөрөмжийн гэрчилгээ болон мэдээлэлийг тараах §8.9 Төхөөрөмжийн гэрчилгээг хүчингүй болгох
32	§ 5.3.32	Тахографын картын гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тахографын картын хугацаатай ижил байна.	§8.4 Төхөөрөмжийн гэрчилгээний хүчинтэй хугацаа
33	§ 5.3.33	ГУЭББ тахографын картад тодорхойгүй хугацаатай гэрчилгээ оруулахаас сэргийлнэ.	§8.4 Төхөөрөмжийн гэрчилгээний хүчинтэй хугацаа
34	§ 5.3.34	Тээвэрийн хэрэгсэлд тодорхойгүй хугацаатай гэрчилгээ оруулахыг ГУЭББ зөвшөөрч болно.	Хэрэглэгдэхгүй
35	§ 5.3.35	ГУЭББ карт олгох явцад карт хэрэглэгчийг адилтган танихыг баталгаажуулна.	§5.1.2.1 Хэрэглэгч хүсэлт гаргах §5.1.9 Хэрэглэгчид картыг түгээх, хүргэх
36	§ 5.3.36	ГУ-ын түлхүүрүүд алдагдсан, хулгайлагдсан, эрсдэлд орсон тохиолдолд ЕСГБ-д нэн даруй мэдэгдэхийн ГУЭББ баталгаажуулна.	§6.2.6 Монголын түлхүүрүүд эрсдэлд орох
37	§ 5.3.37	ГУЭББ ЕСГБ-ын хариу өгөх хугацаанаас үл хамаарсан гамшгаас сэргээн ажиллуулах механизмыг хэрэгжүүлсэн байна.	§6.2.1 Монголын түлхүүр үүсгэх §9.7 МН-ГОБ/МН-КМОБ-ын тасралтгүй ажиллагааны төлөвлөлт
38	§ 5.3.38	ГУЭББ хамааралтай бүх ажиллагааны эрсдэлийн үнэлгээнд суурилан мэдээлэлийн аюулгүй байдалын удирдлагын тогтолцоо (МАБУТ) бий болгоно.	§9.1 МН-ГОБ/МН-КМОБ-ын мэдээлэлийн аюулгүй байдалын удирдлага.
39	§ 5.3.39	Бодлогуудад хүний нөөцийг сургах, шалгах, тэдний үүрэг ролийн талаар тусгасаныг ГУЭББ баталгаажуулна.	§9.3 МН-ГОБ/МН-КМОБ-ын хүний нөөцийн аюулгүй байдалын хяналт
40	§ 5.3.40	Гэрчилгээжүүлэх ажиллагааны бүртгэл, бичлэгийг үйлдэж байгаа гэдэгийг ГУЭББ баталгаажуулна.	§9.6.1 МН-КМОБ-ын бүртгэж байх үйл явдалын төрөл §9.6.2 МН-ГОБ/МН-КМОБ-ын бүртгэж бичлэг болгох үйл явц
41	§ 5.3.41	ГУЭББ өөрийн бодлогодоо ГУГОБ-ыг дуусгавар болгох заалтууд оруулна.	§10 МН-ГОБ/МН-КМОБ-ын ажиллагааг дуусгавар болгох
42	§ 5.3.42	ГУЭББ-ын бодлогод өөрчлөлтийн журамыг оруулна.	§12 УГОБ-ын бодлогод өөрчлөлт оруулах журам

43	§ 5.3.43	Энэ бүлэгийн шаардлагууд хангагдаж байгаа эсэхийг ГУЭББ-ын аудитаар тогтооно.	§11.2 Аудитаар шалгах сэдэвүүд
44	§ 5.3.44	Батлагдсан бодлогод хамаарч буй үйл ажиллагааг ГУЭББ 12 сарын завсарлагатайгаар аудит хийж нягтална.	§11.1 Нийцэлийн аудитын давтамж
45	§ 5.3.45	ГУЭББ аудитын үр дүнг 5.3.43-ын дагуу тайлан болгон гаргаж англи хэл дээр ЕСГБ-д илгээнэ.	§11.5 Үр дүнг танилцуулах
46	§ 5.3.46	тайланд ГУЭББ-ын үүрэгийг биелүүлэхэд шаардлагатай засах залруулах ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх хуваарийг тусгана.	§11.5 Үр дүнг танилцуулах